

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-3

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 4-32

1.Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал	5-6
2.Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайлан	6-10
3.Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан	10-32

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны
11 дүгээр сарын 04-ний өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 32 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 58.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 06 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, Б.Батбаатар, С.Бямбацогт, Л.Гантөмөр, Т.Доржханд, Ц.Идэрбат, Н.Номтойбаяр, Л.Оюун-Эрдэнэ, О.Цогтгэрэл, Л.Энх-Амгалан, Д.Энхтуяа;

Эмнэлгийн чөлөөтэй: Л.Мөнхбаатар.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл үг хэлэв.

Нэг.Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, зөвлөх Ц.Баянмөнх, Ч.Батбямба, референт А.Амармэнд, Б.Баясах, Ц.Болормаа, О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу санал хураалт явуулав.

Ц.Сандаг-Очир: Монгол Улсын Засгийн газраас 2025.10.30-ны өдөр өргөн мэдүүлсэн “Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын Тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	15
Татгалзсан:	3
Бүгд:	18

83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Уг асуудлыг 13 цаг 13 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайлан

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн дарга Н.Монсор, мөн зөвлөлийн гишүүн Б.Ганболд, Ж.Цэсэн, Д.Оюун-Эрдэнэ, Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн ерөнхий

захирал Г.Гэрэл, мөн радио, телевизийн Тамгын газрын дарга Г.Батзаяа, Монголын Үндэсний олон нийтийн телевизийн захирал М.Эрдэнэбат, Монголын Үндэсний олон нийтийн радиогийн захирал Ц.Бямбажаргал, Программын бодлого, зохицуулалтын газрын дарга Н.Байгаль, Техник, технологи хөгжүүлэлтийн газрын дарга С.Сүхбаяр, Санхүү, бүртгэл, хөрөнгө оруулалтын газрын дарга А.Цэвэлсүрэн, мөн газрын ерөнхий нягтлан бодогч Г.Эрдэнэцэцэг, Монголын мэдээ сувгийн ерөнхий продюсер Д.Баяржаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, зөвлөх Ц.Баянмөнх, Ч.Батбямба, референт А.Амармэнд, Б.Баясах, Ц.Болормаа, О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайланг Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн дарга Н.Монсор танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөл 2024 оны үйл ажиллагааны тайлангаа сайжруулах шаардлагатай байгаа тул уг асуудлыг ирэх долоо хоногийн Байнгын хорооны хуралдаан хүртэл хойшлуулах горимын санал гаргав.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэлийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	11
Бүгд:	20

45.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэн дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	13
Татгалзсан:	7
Бүгд:	20

65.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэлийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн:	13
Татгалзсан:	7
Бүгд:	20

65.0 хувийн саналаар горимын санал дэмжигдэж, уг асуудлыг хойшлуулав./13:31/

Гурав.Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Батцэцэг, мөн газрын Үнэлгээ, мониторингийн хэлтсийн дарга Б.Баярсүх, референт Д.Даваасамбуу, ахлах шинжээч Ш.Бумаажав нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, зөвлөх Ц.Баянмөнх, Ч.Батбямба, референт А.Амармэнд, Б.Баясах, Ц.Болормаа, О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, А.Ганбаатар, О.Саранчулуун, Г.Уянгахишиг, Ц.Даваасүрэн, Ц.Сандаг-Очир нарын тавьсан асуултад Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Батцэцэг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг, М.Бадамсүрэн, Ц.Сандаг-Очир нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг сонсов.

Уг асуудлыг 14 цаг 49 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 43 минут үргэлжилж, ирвэл зохих 32 гишүүнээс 20 гишүүн хүрэлцэн ирж, 62.5 хувийн ирцтэйгээр 14 цаг 49 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ц.САНДАГ-ОЧИР

Тэмдэглэл хөтөлсөн:

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
13 цаг 06 минут.

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Сандаг-Очир: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. 2025 оны 11 сарын 4-ний өдрийн Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдааны ирц хүрсэн байна. Хуралдааны ирцэд орсон гишүүдийг танилцуулъя. Оюунсайханы Алтангэрэл гишүүн, Аюушийн Ариунзаяа гишүүн, Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн, Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн, Баярмагнайн Баярбаатар гишүүн, Энхбатын Болормаа гишүүн, Амгаланбаатарын Ганбаатар гишүүн, Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн, Сархадын Зулпхар гишүүн, Чулуунбилэгийн Лодойсамбуу гишүүн, Чинбатын Номин гишүүн, Эрдэнэбилэгийн Одбаяр гишүүн, Цэндийн Сандаг-Очир, Отгоны Саранчулуун гишүүн, Цэвэгдоржийн Туваан гишүүн, Гончигдоржийн Уянгахишиг гишүүн, Бадарчийн Хэрлэн гишүүн нарын гишүүд өнөөдрийн хуралдаандаа ирсэн байна. Ирцийг танилцууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя, 3 асуудал хэлэлцэнэ. Нэгд Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудлыг нэгд хэлэлцэнэ. 2.Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайлан. 3.Хууль, тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан гэсэн 3 асуудлыг хэлэлцэнэ. Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Алтангэрэл гишүүн хэлэлцэх асуудалтай холбогдуулж үг хэлье гэж байна.

О.Алтангэрэл: Энэ Үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөл гээд нэг ийм толгойтой албан бланк дээр 2025 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн албан тоотоор Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Бат-Эрдэнэ танаа гээд нэг тайлан мэдээлэл манай Байнгын хороонд ирүүлж л дээ. Тэгээд энийг нь үзэхээр доор нь гарын үсэг зурсан хүн нь Хяналтын зөвлөлийн дарга Оюун-Эрдэнэ гэж байгаа юм. Тэгээд энэ Олон нийтийн радио, телевизийн хуулийг нь үзэхээр энэ хяналтын зөвлөл нь тэр Үндэсний зөвлөлийнхөө доор байдаг бүтэц байгаад байгаа байхгүй юу. Тэгээд энэ Радио, телевизийнхээ Үндэсний зөвлөлийг төлөөлж явах нь энэ зөвлөл нь өөрөө тэгээд дарга нь байтал энэ Хяналтын зөвлөлийн дарга Оюун-Эрдэнэ гэж хүний ирүүлсэн юм бүхэл бүтэн Улсын Их Хурал руу ирээд, Улсын Их Хурлын бүтцийн байгууллага руу ирээд одоо ингээд хэлэлцэгдэх гэж байна л даа. Энэ тэгээд зөв юм уу?

Тэгэхээр би энэ Үндэсний зөвлөл нь өөрөө ирүүлчихсэн бол бид энийг хэлэлцэх нь зөв байх. Хяналтын зөвлөлийн дарга гэсэн гарын үсэгтэй энэ бичгээр Байнгын хороо хуралдаж, шийдвэр гаргах хууль зүйн үндэслэлгүй л гэж үзэж байгаа учраас хэлэлцэх асуудлын дарааллаас хасаж өгнө үү гэсэн саналтай байна.

Ц.Сандаг-Очир: Үндэсний олон нийтийн радио, телевизийн үндэсний зөвлөлийн 24 оны ажлын тайлан гээд байгаа, тараасан материалын 16 дугаар хуудсанд байгаа байх эргүүлээд харьчихвал Алтангэрэл гишүүн. Хяналтын зөвлөлийнх нь тайлан байгаа, аудитын тайлан байгаа, ингээд 3 материалыг гишүүдэд тараасан байгаа тийм байхаа. Байгаа, байгаа. Үндэсний зөвлөлийн, энэ чинь өөрөө хуулиараа манай Дэгийн хуульд Үндэсний зөвлөлийн, анх удаа хэлэлцэх гэж байгаа юм Үндэсний олон нийтийн, радио телевизийн, тийм. Хяналтын зөвлөлийнх нь ч ирсэн байна лээ. Хяналтын зөвлөл нь Үндэсний зөвлөлөөсөө сонгогддог нь үнэн. Тэгээд анх удаа бид Үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн тайланг хуульд заасны дагуу сонсох гэж байгаа юм. Урьд өмнө ерөөсөө ингэж сонсдоггүй байсан. Дэгийн хуулийн өөрчлөлтөөр ингэж заагдсан.

Тэр хүрээндээ 5 сард тайлан юмаа ирүүлсэн. Ингээд хаврын чуулганд багтаж хэлэлцэж амжаагүй, ингээд бид энэ намрын чуулганаар хэлэлцье гээд ингээд оруулж байгаа юм. Алтангэрэл гишүүний микрофоныг өгье.

О.Алтангэрэл: 2 янз ирсэн юм байна, сая харахад. Энэ Хяналтын зөвлөлийн дарга Оюун-Эрдэнэ гэж нэг зурж ирээд, Үндэсний зөвлөлийн дарга Монсор гэж зурж ирээд 2 тайлан, 1 огноотой, нимгэн, зузаан хоёрын хоёр юм ирсэн юм байна л даа. Тэгэхээр би асуудал дээр яг энэ Үндэсний зөвлөлийн даргынх нь гарын үсэг зуруулж ирснийг хэлэлцүүлье гэдэг тэгвэл ийм санал гаргаж байна.

Ц.Сандаг-Очир: Яг зөв, Үндэсний зөвлөлийнх нь тайланг хэлэлцэнэ. Тийм. Хэлэлцэх асуудал дээр өөр асуулттай гишүүн байхгүй бол хэлэлцэх асуудлаа баталъя. Хэлэлцэх асуудалд оръё.

Нэг.Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал

Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэх тухай асуудлыг хэлэлцье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5.7-д энэ хуулийн 5.1-д заасан жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төсөл өргөн мэдүүлснийг Зөвлөлийн саналыг харгалзан Төрийн байгуулалтын байнгын хороо хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол чуулганаар хэлэлцүүлнэ гэж заасан. Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төсөл бүрээр санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлдье.

Монгол Улсын Засгийн газар Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын Тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийг Соёрхон батлах тухай хуулийн төсөл, Засгийн газар 2025 оны 10 сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн. Соёрхон батлахыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 18 гишүүнээс 15 гишүүн дэмжиж, 83,3 хувиар санал дэмжигдлээ. Өргөдөл дууссан шүү хэн гишүүнээ. Одоо Төрийн байгуулалтын байнгын хороо хуралдаж байгаа. 1 дэх асуудал хэлэлцэж дууслаа.

13:13 цаг

Хоёр.Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайлан

2 дахь асуудал. Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн 24 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэж эхэлье. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 115.1-д Улсын Их Хурлаар хэлэлцэхээр хуульд тусгайлан заасан тайлан, илтгэл, мэдээллийг эрх бүхий байгууллага хуульд заасан хугацаанд Улсын Их Хуралд ирүүлнэ. Дэгийн тухай хуулийн 115.2.11-д Олон нийтийн радио, телевизийн үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны тайланг Төрийн байгуулалтын байнгын хороо жил бүр хэлэлцэнэ гэж заасан.

Ингээд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Оруулаарай, гялс орж ирээд, урдуураа. Албан тушаалтнуудыг танилцуулъя. Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн дарга Н.Монсор, Ж.Цэсэн Үндэсний зөвлөлийн гишүүн, Б.Ганболд Үндэсний зөвлөлийн гишүүн, Д.Оюун-Эрдэнэ Үндэсний зөвлөлийн гишүүн, Г.Гэрэл Үндэсний олон нийтийн радио, телевизийн ерөнхий захирал, Батзаяа Үндэсний олон нийтийн радио, телевизийн Тамгын дарга, Эрдэнэбат Монголын үндэсний телевизийн захирал, Бямбажаргал Монголын үндэсний радиогийн захирал, Байгаль Программ, бодлогын зохицуулалтын газрын дарга, Сүхбаяр Техник, технологи, хөгжүүлэлтийн газрын дарга, Цэвэлсүрэн Санхүү, бүртгэл, хөрөнгө оруулалтын газрын дарга, Эрдэнэцэцэг Санхүү, бүртгэлийн албаны ерөнхий нягтлан бодогч, Баяржаргал Монголын мэдээ сувгийн ерөнхий продюсер гэсэн ийм албан тушаалтнууд хүрэлцэн ирсэн байна.

Хэлэлцэж байгаа асуудалдаа оръё. Олон нийтийн радио, телевизийн үндэсний зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайланг Үндэсний зөвлөлийн дарга Н.Монсор танилцуулна. Монсор дарга ажлын хэсгийн микрофон 6 дээр байгаа юм байна, 6 номерын микрофоныг өгье.

Н.Монсор: Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга болон эрхэм гишүүдээ,

Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн 2024 оны тайланг танилцуулах гэж байна. МҮОНРТ нь өөрийн хуультай, Олон нийтийн радио, телевизийн тухай хууль нь 2005 онд батлагдсан бөгөөд нийт 6 бүлэг 34, 36 зүйлтэй ийм хуулийг Олон нийтийн радио, телевизийн хамт олон маань дагаж мөрддөг. Гол хуулийн зорилт бол олон нийтийн эрх ашигт үйлчилдэг, ашгийн бус, хараат бус радио, телевизийн байгууллагын эрх зүйн үндсийг тогтоодог бөгөөд ил тод, хариуцлагатай, улс төр, ашиг сонирхлоос ангид байх зарчимд тулгуурласан, тулгуурлан ажилладаг болно.

Үндэсний зөвлөл нь Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 20.1 дээр олон нийтийн радио, телевизийн удирдах дээд байгууллага нь Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөл байна гээд заасан байдаг. Мөн 21.1 дээр Үндэсний зөвлөл нь олон нийтийн ашиг сонирхлын төлөөх орон тооны бус байгууллага бөгөөд орон тооны бус 15 гишүүнтэй байна гэж заасан байдаг. Үндэсний зөвлөлийн гишүүд нь, гишүүдийн бүрэн эрх нь 6 жилийн хугацаатай томилогддог. 21.5.1-д Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 4 хүнийг санал болгоно, Монгол Улсын Их Хурлаас 7 хүнийг

санал болгож, Монгол Улсын Засгийн газраас 4 хүнийг санал болгох байдлаар явдаг.

Мөн тухайн хуулийн 21.2-т Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд оруулахаар түүх, уламжлал, ёс заншил, соёл, урлаг, утга зохиол, шинжлэх ухааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд тухайн чиглэлээр мэргэшсэн хүний нэрийг Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхийлөгчид эрх зүй, гадаад харилцаа, сэтгүүл зүй, эрүүл мэнд, боловсрол, биеийн тамир, спорт, байгаль орчин, хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд тухайн чиглэлээр мэргэшсэн хүнийг, мөн Улсын Их Хуралд эдийн засаг, бизнес, техник технологи, удирдлагын менежментийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд тухайн чиглэлээр мэргэшсэн хүмүүсийг бол нэрийг нь Засгийн газар тус тус санал болгодог.

Ц.Сандаг-Очир: Байж байгаарай Монсор даргаа. Таны тайлан нэг биш болоод явчихлаа. Хуулиа яриад байх юм. Та зүгээр Үндэсний зөвлөлийнхөө хийсэн ажлын тайланг чинь л сонсох гэж байгаа шүү дээ. Тэрнээс танай хуулийг бид хэлэлцэх гээгүй.

Н.Монсор: Ойлголоо. Хуульд заасанчлан Үндэсний зөвлөлийн гол хэлбэр нь хуралдаан байдаг. Тэгээд манай Үндэсний зөвлөлийн 15 гишүүн сая түрүүн дурдсан янз бүрийн салбараас мэргэжлийн ийм хүмүүс ирсэн байдаг. 2024 оны хувьд Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөл нь нийт 13 удаа хуралдаж, ээлжит 1 удаагийн хурал хийсэн. Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу ээлжит болон ээлжит бус гэж хуралдаануудыг хийдэг. Нийт 13 хуралдаанаас 25 тогтоол шийдвэр гарсан. Мөн Үндэсний аудитын газраас 2021-ээс 2023 оны Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн үйл ажиллагаанд хийгдсэн гүйцэтгэлийн аудитын хэрэгжилтийн тайланг 25 оны 2 сарын 27-нд 10 тоот албан бичгээр Их Хуралд хүргүүлсэн байгаа.

Үндэсний зөвлөл нь 2024 онд иргэд, байгууллагатай нийт 76 албан бичгээр харилцан хамтарч ажилласан. Үндэсний зөвлөлийн нийт шийдвэрийн биелэлт энэ манай дотоод аудит 92 хувийн гүйцэтгэлтэй байсан гэж үзсэн байна. Энэ нийт 24 онд ингээд хэлэлцсэн асуудлууд бол ингээд байж байна. Анхаарал тавьсан та бүхэнд баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Болчихсон юм уу, бүхэл бүтэн Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн үндэсний зөвлөлийн тайлан уу? Та бүхэн 13 удаа хуралдсан юм байна, ямар асуудлуудыг хэлэлцсэн юм, ямар шийдвэр гаргасан юм, Үндэсний олон нийтийн радио, телевиз чинь одоо үйл ажиллагаа нь ямар байгаа юм, та бүхэн юу гэж дүгнэж байгаа юм, нэвтрүүлгийн бодлого нь ямар байгаа юм, үзэгч, сонсогчдын эрэлт хэрэгцээг хангаж байгаа юм уу, байхгүй юм уу, цаг үетэйгээ нийцэж байгаа юм уу, нийцэхгүй байгаа юм уу, та бүхэн яг удирдах дээд байгууллагын улсууд нь шүү дээ. Улсын Их Хурлаас, Засгийн газраас, Ерөнхийлөгчийн зүгээс сонгогддог, 6 жилийн хугацаатай ийм сууж байгаа улсууд. Тэгээд наад гүйцэтгэх захирлынхаа ажлын тайланг сонссон, ажлын тайланг нь юу гэж дүгнэсэн юм энэ тэр гээд ингээд уг нь их өргөн хүрээтэй асуудлыг ярьж гэж бодсон чинь та чинь тэгээд ийм богинохон хугацаанд ингээд тайлан тавьчихлаа гэж үзэх юм.

Танай хуульд чинь та бүхний бүрэн эрхийг маш тодорхой заачихсан байгаа шүү дээ. Ийм, ийм, ийм үүрэг, чиг үүргийг хэрэгжүүлнэ, төсөв санхүүтэй холбоотой бүх үйл ажиллагаанд төсөв, төлөвлөгөөг нь баталж өгнө, нөгөө талаар хяналт тавина. Тэгээд Үндэсний олон нийтийн радио, телевиз чинь төсөв, төлөвлөгөө нь ямар байгаа юм, орлого, зарлага нь ямар байгаа юм, санхүүгийн хяналт шалгалтаар ямар байгаа юм, болж байгаа юм уу, болохгүй байгаа юм уу, өр, авлага ямар байгаа юм, ажилчдын цалин мөнгө ямар байгаа юм энэ дээр та бүхэн юу гэж үзэж байгаа юм ингээд хуулиар олгогдсон Үндэсний зөвлөлийн бүрэн эрхийг чинь маш тодорхой заагаад өгчихсөн. Энэнийхээ хүрээнд та бүхэн ажлаа тайлагнах ёстой шүү дээ гэж бодсон шүү дээ. Тэгсэн чинь та чинь хуулийн заалтыг бидэнд уншиж өгөнгүүтээ ингээд 13-хан хуралдсан гээд ингээд болчихлоо гэх юм. Хангалтгүй байна шүү дээ энэ тайлан чинь.

Яах юм бэ ахиж хэлэлцэх юм уу? Уг нь гол тайлан таны Үндэсний зөвлөлийн тайланг гол нь та л танилцуулах ёстой юм. Гэрэл захирлаас бид мэдээж Үндэсний олон нийтийн радио, телевизийн асуудлыг ярьж байгаа учраас гүйцэтгэх захирал нь байх ёстой гээд байлцуулж байгаа. Гишүүдийн асуусан асуултад тодорхой хариултыг өгөх ёстой. Ингээд энэ газар, хэлтсийн дарга нарыг чинь Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга нарыг чинь байлгаж, гишүүд асуулт асуувал хариулахад бэлдүүлэх үүднээс та бүхнийг өнөөдөр энэ хуралд оролцуулж байгаа гэж ойлгож байгаа. Гол нь та Гэрэл захирал гэхээсээ илүүтэйгээр Үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн тайлан дээрээ тогтож, гол тайлангаа тавих ёстой шүү. Өөр тайлан байгаа юм уу, болчихсон юм уу?

Яг Үндэсний үйл ажиллагааных нь тайланг бол та Гэрэл захирлынхаа тайланг та нар сонсчихсон юм байгаа биз дээ дотроо, Гэрэл дарга чинь та нарт тайлангаа та нарт тавиад, дүн бангаа авчихсан байх, дүгнэлтээ авчихсан байх. Одоо би таны тайланг сонсох гээд байна шүү дээ. Үндэсний зөвлөл ер нь яг юу хийдэг юм, яг бүрэн эрхээ хэрэгжүүлж чадаж байна уу, үгүй юу? Үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөл үйл ажиллагаа нь хэвийн байна уу, үгүй юу, төсөв санхүүтэй холбоотой асуудал нь хэвийн байна уу, үгүй юу гэдгийг л сонсох гээд байна шүү дээ.

Би танд Үндэсний зөвлөлийн бүрэн эрхийг, та сая хуульд танилцуулаад байсан. Би бас таны бүрэн эрхийг танилцуулъя. Олон нийтийн радио, телевизийн дүрэмд болон тэнд ажиллагсдын ёс зүйн дүрэм батлах нэмэлт, өөрчлөлт оруулах, Олон нийтийн радио, телевизийн үйл ажиллагааны үндсэн зорилт, стратеги төлөвлөгөө, тухайн жилийн төсвийн төслийг хэлэлцэх, Монгол Улсын төсөвт тусгуулах, олон нийтийн радио, телевизийн техник, тоног төхөөрөмж, технологийн сүлжээг хөгжүүлэх, техникийн хангамжийн бодлогыг тодорхойлох, олон нийтийн радио, телевизийн Хяналтын зөвлөл, өргөдлийг шалгах хороог байгуулах, тэдгээрийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах, олон нийтийн радио, телевизийн хөтөлбөр энэ хуульд нийцэж байгаа эсэхэд хяналт тавих, хөтөлбөрт хяналт тавих, Олон нийтийн радио, телевизийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг тогтоох гээд ингээд танд үндсэндээ 11 эрх, үүрэг хуулиар олгогдсон байна. Энэ хүрээндээ тавих ёстой.

Гишүүдээ яах вэ, та бүхэн мэдээлэл авч чадав уу, хойшлуулах юм уу? Алтангэрэл дарга горимын санал гаргая гэж байна. Алтангэрэл гишүүний микрофоныг өгье.

О.Алтангэрэл: Сая Сандаг-Очир дарга хэллээ. Ер нь энэ Үндэсний зөвлөлийн ажиллах үндсэн чиглэлүүд, тайланг яг энэ чиглэлээрээ юу хийсэн юм гээд ингээд бид сонсмоор байна. Яагаад гэвэл Үндэсний зөвлөл чинь өөрөө байгуулагдах гэж зөндөө болдог. Их хурал, Засгийн газар, Улсын Их Хурлаас төлөөлөл нь гараад, Их Хурлаар ороод батлалцаад ингээд явдаг учраас эргэж Их Хуралдаа тайлагнах нь зүйтэй. Зүгээр энэ дээр зохион байгуулалтынхаа хувьд тайлагнах асуудлаа их илүү дэлгэрэнгүй сайн болгоод, эргэж танилцуулах нь зөв байх. Тэгээд туршлагатай хүмүүс зөндөө байна шүү дээ, манай Ганболд эрхлэгчээс авхуулаад. Тэгэхлээр энэ асуудлыг 1 дүгээрт тайлан хэлэлцэхийг хойшлуулмаар байна. Ингэж бид ийм хэмжээний мэдээлэл дээр яамааргүй байна.

2 дугаарт Монсор даргаа би нэг зүйл сануулж хэлмээр байна. Би энэ Байнгын хорооны хуралдааны эхэнд хэлсэн. Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөл гэсэн албан бланктай 2 тайлан Байнгын хороон дээр ирсэн байна, Төрийн байгуулалтын байнгын хороонд хаяглагдаж, 1 нь таны гарын үсэгтэй, 1 нь Оюун-Эрдэнэ гэдэг хүний гарын үсэгтэй. Оюун-Эрдэнэ гэдэг хүн болохоор Хяналтын зөвлөлийг төлөөлж дарга гэж бичсэн байна. Үндсэндээ Монгол Улсын Их Хурлын бүтцийн байгууллага Төрийн байгуулалтын байнгын хороо, Байнгын хороотой таны гарын үсэгтэй, танай Зөвлөлийн асуудлаар харьцана. Энэ асуудал дээр та бүхэн нэг зөвлөл юм бол энийгээ анхаар. Дараагийн удаад тайлангаа илүү сая Сандаг-Очир гишүүний хэлсэн шиг шаардлагад нийцүүлээд ингэж орж ирж хэлэлцэхгүй бол ийм дутуу мэдээлэлтэй тайлан хэлэлцэх ийм бололцоогүй байгаа учраас энэ асуудлыг хойшлуулж өгнө үү гэсэн санал гаргаж байна.

Ц.Сандаг-Очир: Алтангэрэл гишүүнээс хэлэлцэж байгаа асуудлыг хойшлуулах горимын саналыг гаргаж байна. Би ч гэсэн хувьдаа тэгж үзэж байна. Тайлангаа илүү сайн бэлдэх шаардлагатай байна. Яах вэ Үндэсний олон нийтийн радио, телевиз Үндэсний зөвлөл анх удаа Чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд 24 онд өөрчлөлт орсонтой холбогдуулаад манай Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний байгууллага Байнгын хороогоор тайлангаа хэлэлцүүлнэ. Шаардлагатай бол гэж байгаа шүү, шаардлагатай бол нэгдсэн чуулганаар хэлэлцүүлж болно гэсэн ийм хуулийн заалт орсон учраас та бүхэн анх удаа өнөөдөр ТББХ руу Үндэсний зөвлөл тайлангаа танилцуулах гэж байгаа юм. Тэгээд анх удаа ингэж байгаа учраас тодорхойгүй гэдэг юм уу, бүрхэг юмнууд байх шиг байна.

Тийм учраас Үндэсний зөвлөлийн өнөөдрийн Төрийн байгуулалтын байнгын хорооны хэлэлцэх асуудлын дараалалд орсон Радио, телевизийн Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны тайланг хэлэлцэх асуудлыг Алтангэрэл гишүүний гаргасан горимын саналаар хойшлуулъя гэснээр санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалт, горимын саналаас асуух дэг байхгүй шүү дээ. Өөр горимын саналаа? Хураачихъя тэгэх үү? Хойшлуулъя, унахгүй байх, 1, 2. Саналаа хураачхаад, та дараа нь саналаа хэлчих тэгэх үү?

Гишүүд санал хураалтдаа бэлдье. Үнэн, тиймэрхүү асуудал бас байгаа. Ирэх долоо хоногийн хуваарьт оруулъя тэгэх үү? Ирэх долоо хоног хүртэл хойшлуулаад, ирэх долоо хоногийн Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд оруулъя гэсэн ийм Алтангэрэл гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя гишүүд. Санал хураалт. Хэрлэн гишүүн яасан, дэмжээд байгаа юм уу? Та микрофондоо, энэ гацчихаад байгаа юм уу? Та тэгвэл горимын санал гаргая, энэ 2 гишүүний тоног төхөөрөмж ажиллахгүй гацаад байна гэж байна. Баярмаа гишүүн,

Хэрлэн гишүүн хоёр. Хэрлэн гишүүний микрофоныг өгье, микрофон нь ажиллаж байна уу тэгвэл?

Б.Хэрлэн: Микрофон ажиллаж байна. Төхөөрөмж гацсан учраас саяын саналыг хүчингүй болгож, санал хураалтыг ахин зохион байгуулж өгнө үү.

Ц.Сандаг-Очир: Саяын Алтангэрэл гишүүний гаргасан горимын саналыг хүчингүй болгоё гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 20 гишүүнээс 13 гишүүн дэмжиж, 65 хувиар саяын саналыг хүчингүй болгосон. Алтангэрэл гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя, хойшлуулъя гэсэн. Санал хураалт. 20 гишүүнээс 13 гишүүн дэмжиж, 65-аар санал дэмжигдсэн тул ирэх долоо хоногийн Байнгын хорооны хурал орох хүртэл хугацаанд хойшлууллаа. Тэгээд тайлангаа сайн базаагаад ороод ирээрэй. Дараа нь энэ тайланг хэлэлцсэний дараа бид Үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн орон гарах гишүүдийн бүрэн эрхийн хугацаа дууссантай холбогдуулж, гишүүдийг сонгох асуудал хүлээгдэж байгаа цаг хугацааны хувьд. Бүртгэл юмаа авчихсан байгаа. Энэ асуудлуудыг үе шаттайгаар хэлэлцэхээр байгаа. Тэгээд санал дэмжигдсэн учраас 2 дахь асуудлыг ирэх долоо хоног болтол хойшлууллаа.

13.31 цаг

Гурав.Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан

3 дахь асуудал. Энэ Хэрэг эрхлэх газрынхан байгаа юм уу? Дуудчих. 3 дахь асуудалдаа оръё. Хууль, тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг хэлэлцэж эхэлнэ. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 16.2-т Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг ирүүлснээс хойш 10 хоногийн дотор Тамгын газар Байнгын хорооны эрхлэх асуудал дээр дүн шинжилгээ хийж, танилцуулгын хамт холбогдох Байнгын хороонд хүргүүлнэ. 16.3-д Байнгын хороо Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг энэ хуулийн 16.2-т заасан танилцуулгыг хүлээн авснаас хойш 1 сарын дотор хэлэлцэнэ гэж заасан.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Хаана байна вэ, энэ танилцаж байгаа албан тушаал. Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Учрал, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Батцэцэг, Үнэлгээ мониторингийн хэлтсийн дарга Баярсүх, Үнэлгээ мониторингийн хэлтсийн референт Даваасамбуу, ахлах шинжээч Бумаажав гэсэн албан тушаалтнууд оролцож байна. Учрал сайдын микрофоныг өгье.

Н.Учрал: Улсын Их Хурлын Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.9, 16 дугаар зүйлийн 16.1 дэх заалт болон Засгийн газар дахь Хяналтын тухай хуулийн 19.4-д заасныг үндэслэн Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж, дүгнэх журмын 3.7-д заасан аргачлалыг баримтлан Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол,

Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоолын 2025 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээний дүнг танилцуулж байна.

Засгийн газрын хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан new.unelgee.gov.mn Монгол Улсын 79 хуулийн 263, Улсын Их Хурлын 90 тогтоолын 491 заалт, Байнгын хорооны 69 тогтоолын 290 заалт, нийт 238 шийдвэрийн 1044 заалт бүртгэлтэй байна. 2025 оны эхний хагас жилийн байдлаар хууль, Улсын Их Хурлын болон Улсын Их Хурлын Байнгын хорооны шийдвэрийн хэрэгжилт дунджаар 46 хувьтай байна. Тухайлбал Засгийн газрын хяналт шинжилгээ, үнэлгээний цахим системд бүртгэлтэй байгаа Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, Байнгын хорооны тогтоолын хэрэгжилтийг төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газрын харьяа агентлаг, аймаг, нийслэлийн төрийн захиргааны байгууллагаар авч үзэхэд 1044 заалтаас 40,6 хувь буюу 424 нь хэрэгжсэн, 47,7 хувь буюу 498 нь хэрэгжээгүй, 11,7 хувь буюу 122 заалт хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй гэж үнэлэгдсэн байна.

Төрийн байгуулалтын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хууль, Улсын Их Хурал болон Байнгын хорооны тогтоолын хэрэгжилтийг авч үзвэл хуулийн хэрэгжилт тайлант оны эхний хагас жилийн байдлаар Төрийн байгуулалтын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд 11 хуулийн 29 заалтыг төрийн захиргааны төв 16 байгууллага дунджаар 44 хувьтай хэрэгжүүлсэн байна. Үүнээс 28,9 хувь буюу 11 заалт хэрэгжсэн, 36,8 хувь буюу 14 заалт хэрэгжээгүй, 10,5 хувь буюу 4 заалтыг хэрэгжүүлэх хугацаа нь болоогүй гэж тус тус дүгнэлээ.

Монгол Улсын 7 хуулийн 14 заалт хэрэгжээгүй бөгөөд уг заалтаар төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас захиргааны акт, дүрэм, журам, жагсаалт, стандарт зэргийг батлан хэрэгжүүлэх эрхийг олгосон байна. Хэрэгжээгүй 14 заалтаар журам 8, дүрэм 1, заавар, аргачлал, Хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө техник, эдийн засгийн үндэслэл, газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлах тус бүр 1, хөрөнгө оруулагчдын зөвлөл байгуулах зохицуулалтуудыг батлан хэрэгжүүлэхээр байна.

Тухайлбал, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 2022 оны шинэчилсэн найруулгаар улсын баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх төрийн ёслолын арга хэмжээний үндэсний их баяр наадам нь өөрийн бэлгэдэлтэй байх бөгөөд түүнийг хэрэглэх аймаг, сумын баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх нийтлэг журмыг Засгийн газар баталж, мөрдүүлэхээр байна. Мөн Төрийн албаны тухай хуулийн 2017 оны шинэчилсэн найруулгаар Төрийн албан хаагчийг орон байраар хангахад төрөөс дэмжлэг үзүүлэх журмыг, 2023 оны Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулиар нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх журмыг Засгийн газар батлан мөрдүүлэхээр заасан байна. Энэ нь захиргааны акт батлуулах үе шатны ажил болох хэрэгцээ шаардлагыг урьдчилан судлах, төсөл боловсруулах, үр нөлөө, үнэлгээ, зардлын тооцоо хийх, холбогдох байгууллагуудаас санал авах, хэлэлцүүлэг хийх гэх мэт удирдлага зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэхгүй байгаатай холбоотой гэж үзэж байна.

Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийн талаар. Төрийн байгуулалтын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын хяналт шинжилгээ, үнэлгээний цахим системд бүртгэгдсэн 17 шийдвэрийн 46 заалтын хэрэгжилт төрийн захиргааны төв байгууллагын 16 яамдад дунджаар 48,6 хувьтай байна.

Үүнээс 39,1 хувь буюу 18 заалт хэрэгжсэн, 41,3 хувь буюу 19 заалт хэрэгжээгүй, 19,6 хувь буюу 9 заалтыг хэрэгжүүлэх хугацаа нь болоогүй гэж дүгнэсэн байна. Улсын Их Хурлын хэрэгжээгүй 8 тогтоолын 19 заалтыг авч үзвэл Улсын Их Хурлын Улсын Их Хурлын хяналт шалгалт хийсэн холбогдуулан авах арга хэмжээний тухай 2024 оны 9 дүгээр тогтоолын 1.1, 1.3, 1.5, 1.7, 1.8 дахь заалтаар Эрдэнэс Тавантолгой хувьцаат компани, Тавантолгой хувьцаат компанийн үйл ажиллагаатай холбоотой Засгийн газарт даалгасан үүргийн хэрэгжилт үр дүнгүй байна.

Улсын Их Хурлын Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг шинэчлэн баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай 2024 оны 74 дүгээр тогтоолын 1.1.1 дэх заалтаар хууль тогтоомжийг нийцүүлэх чиглэлээр хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулж, 2024 оны 4 дүгээр улиралд багтааж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх үүргийг Хууль зүй, дотоод хэргийн яам хэрэгжүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж ажилласан хэдий ч бүрэн хэрэгжүүлсэн гэж үзэхээргүй байна. Мөн тогтоолын 1.2.2 дахь заалтаар Хотын зөвлөл, захирагчийг, захирагчийн сонгуулийг цахимаар явуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх асуудлыг судалж, танилцуулах үүргийг Засгийн газарт өгсөн хэдий ч Нийслэлийн Засаг даргын Тамгын газар хууль, эрх зүйн орчны судалгааг хийх, зөвлөх үйлчилгээ авч ажиллаж байгаа нь үр дүнгүй байна.

3.Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоолын хэрэгжилтийн талаар. 2025 оны эхний хагас жилийн байдлаар Төрийн байгуулалтын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд гаргасан 4 тогтоолын 17 заалтын хэрэгжилт төрийн захиргааны төв 16 байгууллага дунджаар 35,7 хувьтай байна. Үүнээс 29,4 хувь буюу 5 заалт хэрэгжсэн, 52,9 хувь буюу 9 заалт хэрэгжээгүй, 17,6 хувь буюу 3 заалтыг хэрэгжүүлэх хугацаа нь болоогүй гэж тус тус дүгнэлээ.

Тус Байнгын хорооны 2022, 2023, 2024 оны 4 тогтоолын 9 заалтын хэрэгжилт үр дүн гараагүй байна. Тухайлбал, Улсын Их Хурлын Байнгын хорооны 2022 оны чиглэл өгөх тухай 10 дугаар тогтоолын 1 дүгээр заалтаар Бүх нийтэд жендерийн боловсрол олгох үндэсний тогтолцоог хөгжүүлж, жендерийн тэгш байдлын үзэл баримтлалыг нэвтрүүлэх зорилгоор баталсан Боловсрол, шинжлэх ухааны салбарт баримтлах жендерийн тэгш байдлыг хангах бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх, жендер судлалыг академик түвшинд хөгжүүлэх чиглэлээр ажиллаж байгаа Жендерийн үндэсний хорооны дэргэдэх эрдэмтэн судлаачдын бүлгийг Шинжлэх ухаан, технологийн сангаас дэмжих, эрдэмтэн судлаачдын бүлгийг шинжлэх ухаан, технологийн үйл хэрэгт татан оролцуулах замаар уялдааг хангаж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны яаманд, 2 дугаар заалтаар дээрх үүргийг орон нутагт хэрэгжүүлэхээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт үүрэг болгосон боловч шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд шилжсэнтэй холбоотойгоор хэрэгжүүлээгүй гэж дүгнэж байна.

Хуучнаар Ёс зүй, дэгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах Улсын Их Хурлын байнгын хорооны 2023, 2024, 2025 оны 3 тогтоолын 7 заалтын хэрэгжилтийг ерөнхий байдлаар тайлагнасан, тайлагнах хугацаанд хэрэгжүүлсэн ажил нь үнэлэгдэхүйц ахиц гараагүй, тухайн заалтын хэрэгжилтийг зарим байгууллага ирүүлээгүй байх тул хэрэгжээгүй гэж дүгнэлээ. Хууль, Улсын Их Хурал болон Байнгын хорооны тогтоолын 2025 оны эхний хагас жилээр хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний дүнг 2025 оны 9 дүгээр сарын 10-ны өдөр Засгийн газрын хуралдаанд танилцуулж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлээр

Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг чиглэл өгч, биелэлтийг тооцон ажиллаж байгааг мэдээлье.

Төрийн байгуулалтын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах 11 хуулийн 29, Улсын Их Хурлын 17 заалтын 46, Байнгын хорооны 4 тогтоолын 17, нийт 32 шийдвэрийн 92 заалт бүртгэлтэй байгаагаас 37 хувь нь 34 нь хэрэгжсэн, 45,7 хувь буюу 42 нь хэрэгжээгүй, 17,4 хувь буюу 16 нь хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй гэж тус тус дүгнэгдлээ.

Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны шийдвэрийн хэрэгжилт дунджаар ийнхүү 42,8 хувьтай гэж дүгнэгдлээ. Тус Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах Монгол Улсын хуулийн холбогдох заалтаар төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас захиргааны акт, дүрэм, журам, жагсаалт, стандарт зэргийг батлан хэрэгжүүлэх эрх олгосон 14 заалтаар журам 8, дүрэм 1, заавар, аргачлал, хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, техник, эдийн засгийн үндэслэл, газар зохион байгуулалтын төлөвлөгөө тус бүр 1, нийт 14 баримт бичгийг батлах чиг үүргийг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь захиргааны акт батлуулах үе шатын ажил болох хэрэгцээ шаардлагыг урьдчилан судлах, төсөл боловсруулах, үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоо хийх, холбогдох байгууллагуудаас санал авах, хэлэлцүүлэг хийх гэх мэт удирдлага зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй байгаатай холбож тайлбарлаж байна.

Та бүхэнд Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд заасан Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлэх, дүгнэх журам, Их Хурлын тогтоол, Байнгын хорооны тогтоолын хагас жилийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээний дүнг товч байдлаар танилцууллаа. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Учрал сайдад баярлалаа. Хууль тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлантай холбогдуулж асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү? Бадамсүрэн гишүүнээр тасаллаа. Ганбаатар гишүүн асуултаа, Ариунзаяа гишүүн асуултаа асууя.

А.Ариунзаяа: Төрийн байгуулалтын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах 11 хуулийн 29, 17 тогтоолын 46 заалт, Байнгын хорооны 4 тогтоолын 17 гэсэн ийм чиглэлүүд ирсэн юм шиг байгаа юм тийм ээ. Тэгээд 34 хувьтай л хэрэгжсэн, 46 хувь нь хэрэгжээгүй, 17 хувь хэрэгжих шатад байна гэсэн ийм тайлан сонслоо. 46 хувь нь хэрэгжээгүй буюу хэрэгжих боломжгүй, хэрэгжих хугацаа болоогүй гэдэг ч юм уу, хэрэгжилтийн явцгүй шууд хэрэгжээгүй гэж хаагдсан байгаа нь ямар учир шалтгаантай үүрэг даалгавар өгөгдөөд хэрэгжээгүй гээд хаагдаж байгаа юм бэ? Үүрэг даалгаврын 37 хувь нь л хэрэгжсэн, 37 хувь тийм ээ, 37 хувь хэрэгжсэн гэдэг чинь их л муу дүнтэй байна л гэсэн үг шүү дээ.

Тэгэхээр би юуг хэлэх гээд байна вэ гэхлээр энд нөгөө буруутан хайхаасаа илүүтэй хэрэгжих боломжгүй үүрэг даалгавруудыг нэг талдаа өгөөд байна уу, эсхүл боломжтой үүрэг даалгавруудыг үл хайхарч хэрэгжүүлэхгүй байна уу, ямар учир шалтгаан байна вэ гэдгийгээ хэдүүлээ нэг сайн нягталж харахгүй бол нөгөө л дахиад нөгөө популизм улс төржилт дээр суурилсан үүрэг даалгавруудыг өгөөд байвал энэ чинь угаасаа биелэх боломжгүй гэдэг нь ойлгомжтой. Гэхдээ энийгээ ийм, ийм асуудлууд ийм учраас боломжгүй юм гэдгийгээ нэг хэлэхгүй бол энэ асуудал чинь зогсохгүй, зогсохгүй. Тэгэхээр энэ агуулга дээр нь нэг дүгнэлт анализ хийж танилцуулмаар байгаа байхгүй юу. Тэгээд энийг та бүхэн маань хийсэн үү? Энийг

нэг танилцуулах боломж байна уу? Ингэж байж дараа дараагийн үүрэг даалгаврууд нь 1 дүгээрт цаг хугацаандаа биелдэг байх, оновчтой байх тал дээр нь ажиллахгүй бол энэ төрийн чадамж чинь ердөөсөө нөгөө олон нийтдээ ч тэр, байж байгаа байдал нь ч тэр ердөөсөө бүүр маш хүнд нөхцөл байдалд орж байна шүү гэдгийг онцолж хэлмээр байна.

2 дахь нь болохлоор энэ төсөвтэй холбоотой эргээд л галыг нь Их Хурал руу шидчихэж байгаад жоохон харамсалтай л байгаад байна. Одоо өргөн баригдчихсан байгаа төсөв дотор ямар орон зай гаргаж, яах юм байгаа юм. Төрийн албан хаагчдын өндөр насны тэтгэвэрт гарахад олгох тэтгэмжтэй холбоотой Төрийн байгуулалтын байнгын хороо хууль зүйн дүгнэлт гаргуулаад, Төрийн байгуулалтын байнгын хороо зарчмын зөрүүтэй санал хураалгаж дэмжигдсэн асуудлыг яах вэ гэдэг миний их санаа зовоож байгаа асуудал байна. 178 тэрбум төгрөг манай Байнгын хорооны энэ санал ажлын хэсэг дээр яаж хураагдаж, яаж гарах юм байгаа юм, нэг л бүрхэг болоод явчихлаа. Энэ дээр их санаа зовниж байгаагаа хэлж байна. Ер нь төр өөрөө төрийнхөө гаргасан шийдвэрийг баримталдаг, хуулиа мөрддөг байх нь их чухал юм гэдгийг онцлон хэлье.

Ц.Сандаг-Очир: Ариунзаяа гишүүний асуултад Учрал сайд хариулна.

Н.Учрал: Хэм хэмжээ бол горим журам. Тэгэхээр захиргааны хэм хэмжээ тогтоосон актыг батлуулах үйл явц өөрөө хуулийн хүрээнд явагдах ёстой, нэг ёсондоо үр нөлөөний судалгаа бид хийдэг, хэрэгцээг нь тодорхойлдог, тэгээд зардлын тооцоо хийгээд холбогдох байгууллагуудаас санал аваад захиргааны хэм хэмжээ тогтоосон актыг баталдаг. Ингээд захиргааны хэм хэмжээ тогтоосон актуудыг ХЗДХЯ-нд бүртгэж авдаг. ХЗДХЯ хууль давсан ямар нэгэн хэм хэмжээ тогтоосон заалтууд байгаа эсэх дээр хуулийн давхардал, хийдэл, зөрчил дээр нь дүгнэлт өгөөд, ХЗДХЯ бүртгэдэг. Ингээд Их Хурлын захиргааны актууд системд нэгтгэгдэж байгаа. Дээрээс нь Засгийн газрын хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан new.unelgee.gov.mn дээр нэгтгэгдэж байгаа. Нэг ёсондоо манай улсын хэмжээнд хэрэгжиж байгаа энэ Их Хурлаас баталж байгаа захиргааны актууд, Засгийн газраас баталж байгаа захиргааны актууд нэг мэдээллийн санд нэгтгэхгүй байгаа дээр бид үнэлэлт дүгнэлт хийх ёстой. Тийм учраас сая Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудалд энэ хяналт шинжилгээний үүрэг ирсэнтэй холбогдуулаад Их Хурал, Засгийн газар манай улсад захиргааны хэм хэмжээ тогтоож байгаа нийт актуудыг системийг нь нэгтгэх ажлыг бид ажлын даалгавар гаргаад эхлүүлсэн. Нэгд энийг нэгтгэх шаардлагатай байгаа юм.

2-т Их Хурлын Байнгын хороо тогтоолууд гаргаж байгаа. Их Хурлаас Байнгын хорооноос тогтоол гаргахад Их Хурлын гишүүд санал гаргаад, ажлын хэсэг дээр ч юм уу санал гаргаад хийхэд нөгөө үр нөлөө, нөгөө хэрэгцээ, тэгээд зардлын тооцооллуудыг хийхгүйгээр Байнгын хороо шууд тогтоол гаргаад үүрэгжүүлчихээр яг үнэндээ Засгийн газар түүнийг нь хэрэгжүүлэхэд маш их бэрхшээлтэй байдаг. Тэгэхээр Их Хурлаас баталж байгаа энэ захиргааны хэм хэмжээ тогтоосон актууд ч гэсэн яг энэ хэрэгцээ үнэлгээ, үр нөлөө, зардлын тооцоог давхар хийж байж батлагдаж байвал эргээд энийг дүгнэх бололцоотой болж ирнэ. Ирэх жил ч гэсэн улсын жилийн төлөвлөгөөг, жилийн төлөвлөгөөнд төсөв нийцсэн эсэх дээр бид санал хураадаг. Яг үнэндээ улсын жилийн төлөвлөгөөнд 100 хувь төсөв нийцэх бол маш их бэрхшээлтэй. Яагаад гэвэл энэ нөгөө хүслийн жагсаалт заримдаа болчихоод байгаа жилийн төлөвлөгөө.

Тэгэхээр 5 жилийн чиглэлийг батлах, боловсруулах үүрэг энэ удаагийн парламентад, дээрээс нь сая шинэ бүрдсэн Засгийн газарт оногдсон. Ингээд 5 жилийн чиглэлийн гол онцлог бид хэмжиж болохуйцаар л хийсэн. Нөгөө хүслийн жагсаалт биш, шууд индикаторуудыг тавиад хүрч болохуйц, тодорхой хэмжигдэхүйц, цаг хугацаатай, бодитой гэдэг энэ шалгууруудыг барьсантай адилхан ирэх жил ч гэсэн жилийн төлөвлөгөө 5 жилийн чиглэлдээ нийцээд энэ Байнгын хороо, Их Хурал, Засгийн газар аль ч түвшинд гаргаж байгаа актуудыг яг тэр нөгөө индикаторуудыг нь тавиад хэмжээд явбал ирэх жил Байнгын хороон дээр орж ирээд ингээд 37, 8 хувийн гүйцэтгэл сайн байна гээд ингээд яриад суухгүй юм. Тэгэхээр одоо бол худлаа ярих эрх байхгүй учраас бид яг бодит нөхцөл байдлаа л дүгнэж байгаа юм. Яг л ийм л байна. Олон тогтоол гардаг, олон Их Хурлын тогтоол гардаг, Байнгын хорооны тогтоол гардаг тэгээд яг биелж байгаа байдал нэг ийм л нөхцөл байдалтай байна.

Дээрээс нь энэ дээр нэг зүйл нөлөөлөөд байгаа юу юм бэ гэхээр нөгөө хууль батлаад, хууль баталсантай холбогдуулаад нөгөө журам батал гээд үүрэгжүүлчихдэг. Тэгээд журам батлах гээд нэг журмыг хэлэлцүүлээд, үр нөлөөг нь судлаад, ингээд холбогдох байгууллагаас санал авсаар байгаад хэдэн сар алддаг. Тэгээд хөлгүй, гаргүй олон хууль батлагдаж байгаа. Тэгэхээр энийг бид хаана хаанаа анхаарах ёстой.

Ц.Сандаг-Очир: Ариунзаяа гишүүн тодруулъя, 1 минут.

А.Ариунзаяа: А гэхлээр Б гэдэг шиг хоёулаа өөр л юм яриад явчихлаа. Тэгээд ер нь гол миний санааг авчхаарай. Үүрэг даалгавар нь өөрөө биелэгдэх боломжгүй үүрэг даалгавар өгөөд байгаа бол энийг анхнаас нь зөв даалгавар өгүүлэх тал дээр ажиллах хэрэгтэй шүү. Тэрнээс биш одоо тэгээд л 37 хувийг нь л 100-аас 37 хувийн л хэрэгжилттэй сууж байгаа шүү дээ. Тэгээд Засаг л үүрэг даалгавар биелүүлээгүй байна л гэж дүгнэгдэнэ шүү дээ ер нь бол. Тэгээд энийг хэн нэгэн нь муу биелүүлэхгүй байна гэж харахаасаа илүүтэй анхнаасаа чанартай, биелэгдэх боломжтой үүрэг даалгаврууд өгөгдөж байна уу, юунаас болоод биелэхгүй байна гэдэг л анализыг хийж өгөөч л гэж хүссэн юм.

Төрийн албан хаагчдын тэтгэмжтэй холбоотой 178 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг гаргах хэрэгтэй. Төсвийн ажлын хэсэг энэ дээрээ анхаараарай. Хэрвээ өөрсдөө тэндээ гаргачихвал би ТББХ-н дээр дэмжигдсэн саналаа татаж авахад бэлэн байгаа. Хэрэвзээ эх үүсвэр.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Ариунзаяа гишүүнээ Засгийн газар гүйцэтгэх засаглал бол Их Хурлаас ийм албан даалгавар авмаар байна гэж хүсэлт тавьдаггүй шүү дээ. Тэгээд өөртөө тааралдсан, өөртөө таалагдсан даалгавраа авдаг Засгийн газар гэж юу байх вэ дээ. Байнгын хорооноос үүрэг өгвөл хэрэгжүүлэх гээд л зүтгэж байгаа. Их Хурлын тогтоолоор үүрэг өгвөл хэрэгжүүлэх гээд л зүтгэж байгаа. Тэрнээс биш бид хууль тогтоох дээд байгууллагадаа наад өгөөд байгаа даалгавар чинь үндэслэл бүхий биш байна, бид ийм даалгавар авахгүй гэж хэлэхгүй шүү дээ. Тийм эрх байхгүй. Тэгэхээр шат шатандаа энэ үнэлгээгээ нэгэнт Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх хуулиараа бид авсан бол үнэлгээгээ нэгтгээ гээд бид эхлүүлсэн.

Байнгын хорооноос үүрэг даалгавар өгч байвал түүнийгээ хэмжигдэхүйц байдлаар өгөөрэй гэдгийг бид хүсэлт л тавьж болно. Тэрнээс биш бид Байнгын хороонд шууд нөлөөлөөд наадах чинь мөрөөдөл байна, наадах чинь болохгүй гээд суух эрх хаана хаанаа байхгүй. Тийм учраас үүрэг өгөгдсөн бол хэрэгжүүлэх гээд л ажилладаг.

Ц.Сандаг-Очир: Ариунзаяа гишүүн сүүлийн 1 минут.

А.Ариунзаяа: Учрал сайдаа би чинь сайдаар ажиллаж байсан хүн. Тэгээд нөгөө ямар ч хэлэх эсэргүүцэх боломжгүй, мөрөөдлийн даалгавар байсан ч байсан бид эсэргүүцэх эрхгүй гэдэг чинь буруу шүү дээ. Хэдүүлээ хамтдаа зөв явъя, урагшилдаг байя, зөв үүрэг даалгавар байж зөв л үр дүн гарна биз дээ. Тэгээд энийг л уг нь агуулгынх нь хувьд дүгнээд гаргачихвал анхнаасаа боломжгүй юмаа боломжгүй гэдгийгээ яваад, харин энэ бол мэргэжлийнх нь хувьд, салбарынх нь хувьд ийм асуудал байна гээд ажил хэрэгч мерит ер нь прагматик байдлаар л байвал зөв юм биш үү? Тэрнээс биш тэгээд биелэгдэшгүй даалгавар авчхаад, дээрээс биелэгдэшгүй даалгавар өгсөн ч гэсэн би эсэргүүцэх боломжгүй тэгээд л биелүүлэх гээд зүтгэнэ дээ гээд 30 хувийн л биелэлттэй суугаад байх юм уу гэдэг асуудлыг л яриад байгаа байхгүй юу. Тэгээд энэ дээр.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Учрал сайд.

Н.Учрал: Тийм, би ойлгож байна. Ариунзаяа сайд Засгийн газрын гишүүн байсан хүний хувиар тэгээд Байнгын хорооноос өгсөн үүргийг бид авахгүй гэж хэлэх эрх хаана хаанаа байхгүй. Тэгэхээр та бол өөрөө прагматик байдлаар хандаж, бидэнд ч гэсэн үүрэг даалгаврыг өгөхдөө тийм смарт хэмжигдэхүйц тодорхой, хүрч болохуйц, цаг хугацаатай, бодитой өгөхөд та манлайлж ажиллахыг би хүсье. Тэрнээс биш Их Хурлынхаа тогтоолоор бидэнд үүрэг өгөхөд авна, авахгүй гэх эрх Засгийн газарт бол байхгүй. Тэгээд болгохын төлөө л үе үеийн Засгийн газар хичээж ажилладаг. Тийм учраас зүгээр энэ Эдийн засаг, хөгжлийн сайдын хувиар миний эрхлэх асуудалд байгаа энэ хяналт хэрэгжүүлэх тогтолцоог өөрчлөх гээд 5 жилийн чиглэлийг хэмжигдэхүйц хийсэн шүү. Дээрээс нь ирэх жил үнэлгээнүүдийг нэгтгэнэ, тэгээд ажлуудаа хийж байгаа л гэж хэлье.

Ц.Сандаг-Очир: А.Ганбаатар гишүүн асуултаа асууя.

А.Ганбаатар: Төрийн байгуулалтын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах 7 хуулийн 14 заалт, мөн Байнгын хорооны тогтоолын 4-хөн шийдвэр буюу 16 заалтын хэрэгжилтийн, хэрэгжилтэд шинжилгээ хийсэн байна л даа. Тэгээд 28,6 хувьтай гэж байгаа юм. Энэ хэрэгжилт маш бага байна гэсэн тоо харагдаж байна. Тайланг харахад хэрэгжээгүй гэсэн дүгнэлтэд орсон асуудлын дийлэнх нь буюу 50-аас дээш хувь нь шалтгааныг нь тайлбарлаагүй байгаа юм. Юунаас болж хэрэгжээгүй юм бэ гэдэг. Засгийн газартай холбоотой олон асуудал дээр хугацаа болоогүй байна гээд хариулт ирсэн. 25 он дуусах гээд 11 сар гарчихсан байхад 23 онд гарсан тогтоолын хэрэгжилтийг 25 оны 3 дугаар улиралд тайлагнах үүрэгтэй. Ингэхээр хугацаа болоогүй гэсэн ийм асуудал тавьж байгаа юм байна лээ.

Тэгээд асуулт нь болохоор Их Хурлаас батлагдсан хууль тогтоомж үүнийг Засгийн газар, хэрэгжүүлэх ёстой байгууллагууд нь хэрэгжүүлэхгүй бол яадаг юм бэ? Хэрэгжүүлээгүй бол ямар санкц, хууль, дүрэм байдаг юм бэ? Хэрэгжүүлээгүй, хэрэгжүүлээгүйн улмаас хариуцлага тооцуулсан эрүүгийн болон захиргааны

шийтгэл хүлээсэн албан хаагч, албан тушаалтан байна уу, тэгвэл яагаад? Тэгээд бид хэрэгжихгүй хууль хийгээд байгаа нь амьдралд нийцэхгүй байгаад байгаа юм уу, эсвэл хуулийг нь хэрэгжүүлэх ёстой хүмүүс нь албан тушаал, энэ албан үүрэгтээ хариуцлагагүй хандаад байгаа юм уу гэдгийн ялгааг энэ тайлан тодорхой гаргаж ирээгүй байна л даа. Тэгээд энэ яг учраа олчихвол ямар учраас энэ хууль тогтоомж хэрэгжихгүй байна вэ гэдэг дээр Их Хурал дүгнэлт хийгээд, гарах хуулиуд дээр бид судалгаа шинжилгээтэй ингээд ажиллах ёстой. Учрал сайдаас асууж байна л гэсэн үг л дээ Засгийн газрын Хэрэг эрхлэх газар байсан, дээр нь тэргүүлэх сайд хийж байгаа. Хууль, дүрэм хэрэгжүүлээгүй албан тушаалтан, албан хаагчдад ямар хариуцлага үүрэг тогтоол оногдсон бэ? Ийм асуулт байгаа юм.

Ц.Сандаг-Очир: Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Тэгээд биелэгдэж байгаа энэ гүйцэтгэл тийм маш бага хувьтай харагдаад байгаа дээр бид яалт ч үгүй л үнэлгээ хийх ёстой. Тэгээд хуулийн үр дагаврын үнэлгээг бид хийдэггүй болохоор тухайн зохицуулалт нь хэрэгцээтэй эсэх үгүй нь тодорхойгүй яваад ирчихсэн байна. Тийм учраас жишээ нь ингээд заалт болгоноор нь гаргаад энэ, энэ заалт хэрэгжээгүй байна гээд явуулахаар яг агуулгын хүрээнд биелчихсэн ийм заалтууд бол байгаа юм. Тэгэхээр энэ үнэлгээ бол ахиж дэвших, дээшлэх боломж байгаад байгаа юм. Гэтэл нөгөө хуулийн кодификац байхгүй, нэг ёсондоо биелэгдсэн гээд байгаа 1374 заалт байгаа байхгүй юу, тэрийг нь хасуулах гээд өгөхөөр кодификац хийдэггүй болохоор ингээд хасаагүй хяналтад яваад, энэ нөгөө гүйцэтгэл их тийм бага гарч харагдаад байдаг.

Тэгэхээр цаашдаа Их Хурлын Тамгын газар би Их Хурлын гишүүний хувиараа ч гэсэн Тамгын газраас хүсэлт тавьж байна. Хуулийн үр дагаврын үнэлгээг хийдэг, түүнийгээ тайлагнадаг болох хэрэгтэй байна. Дээрээс нь энэ кодификац хийдэг болмоор байна. Бидэнд энэ заалт чинь хэрэгжихсэн юм биш үү гээд агуулгаараа хэрэгжсэн гээд илгээхээр заалт болгоноор нь, механикаар нь ингээд энэ заалт хэрэгжээгүй, хэрэгжээгүй гээд тавиад байхаар энэ гүйцэтгэл чинь аягүй бага гараад байна. Тэгэхээр хуулийн кодификац хийх асуудлыг анхааралдаа авч өгвөл, Их Хурлын Тамгын газар авч өгвөл маш сайн байна. Тэгээд нэг ийм хэд хэдэн бэрхшээлүүд зайлшгүй байна. Яах вэ энэ удаа нөгөө төлөвлөж байгаа механизм чиг үүрэг өөрөө Эдийн засгийн хөгжлийн яаман дээр байна. Дээрээс нь эргээд мониторинг хийх үүрэг нь Эдийн засаг, хөгжлийн яаман дээр байна.

Тэгэхээр төлөвлөөд, төсөвлөөд, хянаад мониторинг хийх, дизайн хийгээд мониторинг хийгээд evolution хийнэ гэдэг энэ циклээрээ явна. Тэгэхээр энэ циклийг эргэлдүүлэхийн тулд бид нэгд үнэлгээний системийгээ нэгтгэхчье 1-д. 2-т хаана хаанаа нөгөө хуулийн үр дагаврын үнэлгээгээ хийдэг болчихье. Тэгээд зарим заалтууд дээрээ кодификац хийе. Ингээд эхлэхээр энэ үнэлгээ ахиц гарна. Тэгээд анхнаасаа төлөвлөхдөө индикаторуудаа зөв тавья. Жишээ нь 5 жилийн чиглэл эдийн засгийн эрх чөлөөний индексээр эрэмбээрээ эхний 60-д орно л гэж байгаа юм 5 жилд. Тэгвэл эхний жил яах вэ 3 байр урагшилна л гэж байгаа юм. 3 байр урагшлахад ахиц үзүүлээгүй бол хангалтгүй л гэж үнэлнэ. Тэрнээс биш тэр эхний 60-д орохын тулд хууль хэлэлцүүлсэн байна уу, формоо хийсэн байна уу, арга хэмжээ зохион байгуулсан байна уу тэр ерөөсөө хамаагүй. Ерөөсөө л хангалттай, хангалтгүй. Ингээд л үнэлгээ хийнэ. Энэ үнэлгээтэй нь тохируулаад тэр гүйцэтгэлийн индикаторуудыг тавих байхгүй юу.

Өнөөдөр энэ багш, эмчийн цалин дээр ч гэсэн асуудал юунаас болоод байна маш ойлгомжтой шүү дээ энэ чинь KPI-г бид хэрэгжүүлж чадахгүй байгаа байхгүй юу? Индикаторууд нь ойлгомжгүй, тэгээд гүйцэтгэлийг яаж төлөвлөхөө бүрэн тэр механизм руу нь оруулж чадаагүй. Тэгээд өнөөдөр тэр KPI хийхийн тулд яг тэр нөгөө хувийн байгууллагууд бүгдээрээ л энэ balanced scorecard гээд л хийдэг шүү дээ. Хийх юм уу, эсвэл яг гүйцэтгэлийн үнэлгээ дээр 360 градус хэрэгжүүлэх гээд байгаа юм уу, feedback хийх гээд байгаа юм уу. Энэ нөгөө ямар замаар, яаж явах вэ гэдгээ тодорхой болгоогүй байгаа учраас эргээд ингээд Их Хурал дээр ч гэсэн ороод ирэхэд бид ойлголцохгүй байдалд байгаа байхгүй юу. Тийм учраас энийгээ л зөв болгоё гээд энэ 5 жилийн чиглэлээс эхэлсэн. Тэгэхээр 5 жилийн чиглэл ирэх долоо хоногоос хэлэлцээд эхлэхээр би нэмэлт тайлбаруудаа өгөөд явъя. Тэр хариуцлага тооцсон асуудал дээр ажлын хэсгээс яг тоо баримтууд илтгэх байх.

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн хэдэн номерын микрофон юм бэ? 5 номерын микрофон.

Б.Батцэцэг: Ажлын хэсгийн гишүүн Батцэцэг Хяналт хэрэгжүүлэх газар. Хууль тогтоомжийн биелэлтийг тооцож, үр дүнг тайлагнадаг болсноос хойших хугацаанд өмнө нь Засгийн газар дээр Хөвсгөл, Архангай, Завхан аймгийн Засаг дарга нарт хариуцлага тооцох арга хэмжээ авч хэрэгжүүлж байсан юм байна лээ. Үүнтэй холбоотойгоор мөн 3 яаман дээр Төрийн нарийн бичгийн дарга нарт холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооц гэдэг асуудал бас хөндөж тавьсан. Энэ удаагийн хууль тогтоомжийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээний тайланд үндэслээд ЗГХЭГ дээр Засгийн газрын тэмдэглэлээр үүрэг өгсний дагуу төсвийн ерөнхийлөн захирагчид болон Засаг даргын тамгын газруудад 11 сарын 1-ний дотор хугацаатай үүрэг чиглэл өгсөн албан бичиг хүргүүлсэн байгаа. 11 сарын 15-ны дотор тайлангаа буцаж Хэрэг эрхлэх газар дээр тайлагнах ёстой.

Ц.Сандаг-Очир: Ганбаатар гишүүн тодруулъя, 1 минут.

А.Ганбаатар: Учрал сайдын хариулж байгааг харахад нөгөө үнэлгээ, үнэлгээний систем нь буруу байна гэж хэлж байна л даа. Дутуу байна, болоогүй байна гээд. Тэгээд үнэхээр тийм бол Их Хурлын Тамгын газар Засгийн газрын Хэрэг эрхлэх газар 2 хоорондоо уялдаатай ажиллаад тэр KPI байна уу, үнэлэх системүүдээ ямар арга зүйгээр хийх юм бэ гэдгээ маш хурдан тодорхой болгоод, ингээд энийгээ хэрэгжүүлэхгүй бол магадгүй зарим албан тушаалтан, албаны хүмүүс хохирох асуудал гарч ирж магадгүй юм байна шүү дээ. Яагаад гэвэл энэ хэрэгжилттэй холбоотой үнэлгээ нь үнэлэх систем нь буруу байгаа учраас цаг хугацаандаа шахуулдаг юм уу, эсвэл амьдралд нийцэхгүй, хэрэгжихгүй ийм хууль тогтоомж гарчихсан түүнийг нь хэрэгжүүлэхэд бодит байдал дээр хэцүү байгаа бол төрд ажиллаж байгаа хүмүүс хэлмэгдэх ийм магадлал байна. Тэгэхээр Учрал сайд Их Хурлын Тамгын газартай хамтарч ажиллаад, хэдий.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Ахиад нэмэлт 1 минут сүүлчийн Ганбаатар гишүүн.

А.Ганбаатар: Санал санал юм. Тэгэхээр хурдан хоорондоо хамтарч ажиллаад энэ ажлаа голдиролд нь оруулаарай гэж санал хэлье.

Ц.Сандаг-Очир: Саранчулуун гишүүн асуултаа асууя.

О.Саранчулуун: Сайн байцгаана уу? Надад хэд хэдэн тодруулах зүйл байгаад байна. Өнгөрсөн жилд хүний, Нийгмийн бодлогын байнгын хорооноос жишээлбэл нэг тогтоол гарсан байгаа. Тэр нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой ийм тогтоол байгаа. Тэгээд тэр энэ тэр энэ материал дотор тайланд ороогүй юм байна. Тэгэхээр бодвол нөгөө хугацаа нь болоогүй гээд хойшилсон болов уу гэж би тайлбараас сонслоо. Тэгээд яах вэ надад ингэж бодогдоод байна. Ер нь энэ хууль өргөн барихаар хууль өргөн барьж байгаа тохиолдолд гишүүд Засгийн газар луу явуулж санал авдаг. Тэгээд Засгийн газар буцаагаад ЗГХЭГ-аас энэ тухайн хуультай холбоотой саналаа өгдөг, тэр санал явдаг нэг процесс байна. Тэрэн шиг ер нь энэ Байнгын хорооны тогтоол болон Улсын Их Хурлын тогтоолууд дээр тавигдах процесс нь арай ялгаатай харагдаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дээр та хэд нэмж шалгуур гаргаж, сайжруулах тухай асуудлыг ер нь ярьж байна уу?

Нөгөө талдаа эсрэгээрээ Засгийн газраас, газрын зүгээс Их Хурлын гишүүдийн өргөн барьж байгаа хуулийн төслүүд дээр буцаагаад өгч байгаа санал дээрээ шалгуур, яамнуудын тэр шалтгаан, тайлбараа сайжруулахтай холбоотой асуудал энэ дээр ярьж байгаа юу? Энэ чинь нөгөө институт хоорондын харилцаа яриад байна шүү дээ, энийг тодруулмаар байгаа?

Ингээд хууль тогтоомж биелээгүй юм байна. Үүнтэй холбоотой зардал, алдагдал гарч байгаа төсөв дээр ч юм уу, эсвэл тухайн хийх ёстой ажил хийгээгүйгээс болоод хаа нэгтээ зардлын алдагдлууд гарч байгаа. Тэр зардал төсвийг нь яадаг юм бэ буцаагаад татдаг юм уу, эсвэл буцааж нөхөн олгодог уу энэ дээр нэг тодруулмаар байна?

Ер нь яах вэ энэ тайланг харахлаар би энэ тогтоол шийдвэрүүдийг ер нь биелсэн, биелээгүй гэдэг шалгуур нь тодорхойгүй гэдгийг хараад байна. Энэ хэдэн тогтоол нь цаг хугацаагүй байсан учраас биелээгүй байна ч гэдэг юм уу, ер нь энийгээ ингээд цаг хугацаагаар нь ангилаад гаргачихдаг, эсвэл ингээд салбар чиглэлээр нь гаргаад ангилчихдаг, эсвэл эзэн биеэр нь гаргаад ангилчихдаг ийм тайлбар энэ тэр тайлан гаргаж танилцуулж болохгүй байсан уу гэдгийг асууя?

Тэгээд бидний өнөөдрийн энэ сонсож танилцаад, тэгээд дараа нь яах юм бэ? Бидний энэ ТББХ дараа нь яг ямар шийдвэр гаргахыг, гарахыг би асуумаар байна л даа. Бид ингээд биелээгүй байна гэдэг энэ 37 хувьтай хангалтгүй байна гэдгийг сонсчихоод, асуулт асууж дуусгачхаад, тэгээд дуусдаг юм уу? Одоо процесс яах ёстой вэ?

Хамгийн сүүлд нь ер нь энэ нөгөө тавьж байгаа шалгуурууд дээр олон улсын гэрээ конвенцоор хүлээсэн үүргүүдийг хэр тусгагддаг юм бэ энэ хэмжүүр дээр гэдэг ийм тодруулах зүйлс байна?

Ц.Сандаг-Очир: Хэн хариулах вэ? Ажлын хэсгийн 5 номерын микрофон.

Б.Батцэцэг: Гишүүний асуултад хариулъя. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн асуудлаар гарсан тогтоолын хэрэгжилтийг Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороон дээр хагас жилийн байдлаар бид тайланг нь танилцуулна. Өнөөдрийн хувьд зөвхөн ТББХ-нд хамаарах тогтоолын танилцуулга, хэрэгжилтийн хууль тогтоол, тогтоомжийн хэрэгжилтийн танилцуулга хийгдэж байна.

Юуны, яг энэ нөгөө хууль тогтоомжийг үнэлэх дээр бидэнд асуудал байгаа. Бид энийг Их Хурлын Тамгын газартай маш олон чиглэлээр ярьж байгаа. 1 дүгээрт яг түрүүний сайдын яриад байсан кодификацын асуудал, нийцлийн асуудал, мөн бидний хяналтад авч байгаа 2 өөр систем ашигладаг бид. Их Хурлын хяналтад байгаа систем нэг өөр, Засгийн газрын хяналтад байгаа систем нэг өөр. Тэгэхээр бидний хоорондын ажлын уялдаа холбооны асуудал бас гарч ирж байгаа. Бид Их Хурал дээр Үнэлгээ мониторингийн газартай энэ асуудлаа шийдвэрлэх системийн систем холболтыг харилцан саадгүйгээр хийх асуудлыг ярьж байгаа.

Хоног хугацаатай гардгийн хувьд яг өнөөдрийн хувьд бид хууль тогтоомжийн хэрэгжилт ярьж байгаа учраас ихэнх нь хоног хугацаагүй гардаг. Ялангуяа хууль, Их Хурлын тогтоолууд, Байнгын хороон дээр зарим хоног хугацаатай тогтоолууд гарч ирдэг. Их Хурлын хууль тогтоомжийг, хуулийг хяналтад авахыг ч гэсэн бид бодох хэрэгтэй. Хууль өөрөө ингээд хагас жил, бүтэн жилээр үнэлэгдээд байх үнэлгээний объект мөн үү, биш үү. Хууль өөрөө тэр чин Хууль тогтоомжийн хуулиар бид үнэлгээ мониторинг нь 5 жил тутамд хийх ёстой гээд хуульчилчихсан байж байдаг. Гэтэл бид хэдэн нөгөө журам батална гэдэг заалтуудыг түүж аваад ингээд хагас, бүтэн жилээр үнэлгээнд оруулаад байдаг, түүгээрээ тухайн хууль хэрэгжээгүй, эсхүл хэрэгжсэн байна гэж үнэлэх өөрөө их өрөөсгөл юм шиг байгаа юм. Тэгэхээр бид энийг Их Хурлын Тамгын газартай нэлээн ярьж байгаа. Цаашид ажил сайжруулах юм хийгдэнэ.

Энэ удаагийн үнэлгээ бол өмнөх үнэлгээнээсээ харьцангуй магадгүй буюгаад ороод ирсэн байх. Бидэнд үнэлгээ дээр ямар асуудал үүссэн гэхээр хууль тогтоомжийн хэрэгжсэн, үгүй дээр шалгуур үзүүлэлт гэдэг юм байхгүй л дээ. Тэгээд бид яаж гаргаж ирсэн гэхээр нөгөө хэрэгжсэн гээд байгаа заалтуудаа нийт юунд байгаа хяналтад байгаа заалтуудаасаа хугацаа болоогүй заалтуудаасаа 100 хувиар үржүүлээд ингээд хувийг нь гаргаж ирээд, 85-аас дээш хувьтай байвал энэ бүрэн хэрэгжлээ, 85-аас доош хувьтай байвал огт хэрэгжээгүй гээд. Тэгэхээр нөгөө 30-аас 85 хүртэлх хувийн хэрэгжилттэй процесс явж байгаа хууль тогтоомж дандаа хэрэгжээгүй гэдэг заалттай юутай үнэлгээтэй орж ирж байгаа гэсэн үг.

Тэгээд дараагийн нэг асуудал нь болохоороо энэ нөгөө хагас жилийнх. Бид одоо 11 сард ярьж байгаа боловч хагас жилийнх буюу 6 сарын 31-нээр тайлагнасан. Тэгэхээр дараагийн тайлагналд орж ирэхдээ бүтэн жилээрээ орж ирнэ. Юуны хувьд Их Хурлын Тамгын газраас илүү хариулах байх. Миний мэдэж байгаагаар хууль тогтоомжийн биелэлт хагас жилийн үнэлгээг танилцуулна.

Ц.Сандаг-Очир: Саранчулуун гишүүн тодруулъя, 1 минут.

О.Саранчулуун: Тэгэхээр энэ биелээгүйгээс үүдэлтэй алдагдсан өртөг, санхүүгийн асуудлыг яадаг юм бэ гэж тэрийг тодруулбал хэрэгтэй байгаа? Тэгээд хариуцлага хүлээх, жишээлбэл тогтоолын биелэлт дээр чинь тогтоол нь өөрөө хэрэгжих боломжтой байсан уу, тогтоол нь өөрөө цаг хугацааны хувьд болон KPI нь ойлгомжтой байсан уу гэдэг нэг асуудал. Нөгөө талд ойлгомжтой тогтоол гаргачхаад байхад тэрийг хэрэгжүүлж хийгээгүй тэр хариуцаж байгаа хүмүүс дээр хариуцлагаа ингэж хариуцлага тооцох ёстой гэдгийг нь яаж хэмждэг юм бэ? Түрүүн ингээд 2, 3 Засаг дарга нарт жишээлбэл хариуцлага үүрүүлсэн гээд тэгж байна. Тэгэхээр энэ ямрыг нь хариуцлага үүрүүлэх ёстой гэж үзээд, ямар нь ингээд орхиод цаашаагаа явчихдаг юм гэдэг асуудал байгаа. Өнөөдрийн Байнгын хорооны би анх удаа л

сонсож байгаа болохоор асуугаад байна л даа. Одоо тэгээд яах юм бэ, бид жишээлбэл энэ дээр ямар нэмэртэй вэ, өнөөдрийн энэ яриа хэлэлцүүлгээс юу гарах юм бэ шийдэл нь?

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн 5 номер.

Б.Батцэцэг: Гишүүний асуултад хариулъя. Юун дээр Төрийн албаны тухай хуулиар энэ хууль тогтоомжийн хэрэгжилт төрийн албан хаагч, төрийн байгууллага болон албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд жижгэрч тусаж орж ирдэг. Түүгээрээ албан хаагчид маань үнэлэгдээд явж байгаа. Байгууллагуудын хувьд бид мөн саяхан тайлан дээр дурдагдсан тайлан ирүүлээгүй гэсэн байгууллагууд байгаа. Үүн дээр хариуцлага тооцож, буцаж мэдэгд гэдэг албан бичгийг 3 яаманд Хяналт хэрэгжүүлэх газрын зүгээс хүргүүлсэн байж байгаа. Алдагдсан боломжийн хувьд яг саяын сайдын яриад байсан бид нөгөө нэг үр дүнгээ үнэлж чадахгүй байгаа учраас нөгөө буцаад үнэлгээ дизайн, мониторинг, эволюшн гэдэг процесс чинь өөрөө зөв голдиролдоо орж явж чадахгүй байгаа. Энийг бид зайлшгүй сайжруулах ёстой. Яг надад энэ хууль тогтоомж хэрэгжээгүйгээс тэр төсөв нь хураагдсан.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Саранчулуун гишүүн 2 удаа асуугаад байна. Одоо бид яах юм бэ ингээд хангалтгүй байна гээд 30 хэдэн хувьтай байна зөвхөн манай Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд байгаа хууль тогтоолын хэрэгжилт гээд. Тэгээд цаашдаа бид Байнгын хорооны гишүүд санал санаачилга гаргаад, ийм хэрэгжилт хангалтгүй байгаа тохиолдолд ажлын хэсэг гаргаад, Байнгын хороон дээрээ яриад, энэ хууль тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр тогтоол, шийдвэрийн биелэлтийг сонсоод, ажлын хэсэг гаргаад, энэ дээрээ эрчимжүүлэх чиглэлээр гаргаад ажиллаж болно. Засгийн газарт үүрэг чиглэл өгч болно. Энэ эрх манай Байнгын хороонд бүрэн эрхэд нээлттэй байгаа. Ингэж ажиллахгүй бол зүгээр өнөөдөр ингээд хэрэгжилт дутуу байна, сул байна, муу байна гээд ингээд сонсоод хаячих юм байхгүй.

Гишүүд өөрсдөө ажлын хэсэг гаргаж ажиллая, эрчимжүүлнэ, биелэлтийг нь эрчимжүүлэе гээд Дэгийн тухай хуулийн 22.3.4 дээр ч байгаа. Хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгах хүрээнд Засгийн газрын хуулийн биелэлтийг зохион байгуулж, хангах үйл ажиллагаанд хяналт тавих, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлэх чиглэлээр гээд байгаа учраас энэ эрхийнхээ хүрээнд Байнгын хороо цаашдаа ажлын хэсэг гаргаад, эрчимжүүлэх чиглэлээр ажиллахад нээлттэй байгаа. Дараагийн гишүүн Уянгахишиг гишүүн асуултаа асууя.

Г.Уянгахишиг: Ерөнхийдөө нөгөө түрүүн Учрал гишүүний хэлсэн тайлбар бол яг түрүү жил бид хэлэлцэж байхад яг адилхан тайлбар явж байсан санагдаж байна. Тэгэхээр 5 жилийн төлөвлөгөөгөө хэлэлцээд батлуулчихаар KPI арай тодорхой болох юм байна гэж ойлголоо зөв үү 1 дүгээр асуулт?

2 дугаарт болохоор яг энэ юунаас хяналт шалгалт тайлан хэлэлцсэн санал, дүгнэлт дээр байна л даа. Саяын яг Саранчулуун гишүүний хэлсэнчлэн, Байнгын хорооны даргын хэлж байгаачлан Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д Улсын Их Хурал шаардлагатай гэж үзвэл хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, эрчимжүүлэх, хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, холбогдох албан тушаалтны хариуцлагын асуудлыг хуульд заасны дагуу шийдвэрлүүлэхээр тогтоол гаргана гэсэн ийм

үндэслэл байгаад байгаа юм. Тэгэхээр энэний энэ асуудлыг цаашаа авч хэлэлцмээр байна. Шаардлагатай тохиолдолд яг энэ хэсэгчилсэн асуудлууд дээрээ ажлын хэсэг гаргаад ажиллуулах ийм саналтай байна.

Нарийвчилсан яг энэ хэрэгжээгүй Улсын Их Хурлын тогтоолуудын энэ заалттай холбоотойгоор 2 асуулт байгаад байгаа юм. Энэ дээр бид Монгол Улсын Их Хурлаас Хянан шалгах түр хороо байгуулдаг, сонсгол зохион байгуулдаг. Энэ дээр маш их хүмүүсийн цаг зав, мөн түүнчлэн маш их олон хэлэлцүүлгүүд, хуралдаанууд болдог. Энэ дээр бараг л мөрдөн байцаах ажиллагаа шиг юм болдог шүү дээ. Энэ дундаасаа жишээлбэл нүүрсний сонсгол гээд л тэнчээнээс хэчнээн олон хүмүүсийн нэр төр, ажил яригдав, тэнчээнээс ямар олон асуудлууд яригдсан. Тэгэнгүүт тэрэнтэй холбоотойгоор энэчээ Их Хурлын хяналт шалгалттай холбоотой 24 оны 1 сарын 16-ны тогтоолын хэрэгжилт дээр хэрэгжилтийг бүрэн тайлагнаагүй гэдэг 3, 4 асуудал байгаа байхгүй юу. Хөгжлийн банкны түр хороотой холбоотой бас 2 асуудал байна. Бас бүрэн хэрэгжээгүй, хэрэгжээгүй гэж үзлээ гэдэг. Тэгэхээр энэ асуудлууд дээр илүү тодорхой нарийвчилсан тайлбар авмаар байна.

Өөрөөр хэлбэл энэ хүснэгтээс ямар ч мэдээлэл авч чадахгүй байгаад байгаа байхгүй юу. Яагаад жишээлбэл Хөгжлийн банкныг цогцоор нь иж бүрэн өөрчлөн зохион байгуулж, холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах төслийг боловсруулах гэдэг энэ тогтоол хэрэгжээгүй юм бэ? Яагаад энэ ажил хийгдэж чадаагүй юм бэ, хийгдээгүй шалтгаан нь юу юм бэ гэдгийг жишээлбэл мэдмээр байна. Хөгжлийн банктай холбоотой хүлээсэн үүргээ биелүүлээгүй албан тушаалтны хариуцлагын асуудлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх гэдэг энэ асуудал яагаад шийдэгдээгүй юм бэ? Энэ дээр хариуцлага хүлээлгэх нь хэний хариуцлагын асуудал байсан юм бэ гэдгийг тодорхойлмоор байна.

Мөн түүнчлэн нүүрсний сонсголтой холбоотойгоор Эрдэнэс Тавантолгой, Тавантолгой хувьцаат компани болон төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой бусад хуулийн этгээдээс цаашид төсвийн шинжтэй компанийн үйл ажиллагаанд хамааралгүй хөрөнгө оруулалт, төслийг санхүүжүүлэхгүй байх, хориглох арга хэмжээг авах гэдэг энэ хэрэгжилтийг бүрэн тайлагнаагүй гэж байна. Тэгэхээр хэрэгжээгүй юм уу, хэрэгжсэн юм уу буюу энэ нь зөвхөн тайлангийн, тайлагналын асуудал юм уу, хэрэгжээгүй юм уу гэдэг дээр бас.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Тодруулга 1 минут Уянгахишиг гишүүн.

Г.Уянгахишиг: Мөн түүнчлэн яг энэ нүүрсний сонсголтой холбоотойгоор Эрдэнэс Тавантолгой хувьцаат компани, Тавантолгой хувьцаат компани болон төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой бусад хуулийн этгээдийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг иргэд олон нийтэд ил тод, нээлттэй зохион байгуулах чиглэлээр Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулж, 24 оны 1 дүгээр улиралд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх гэдэг ийм чиг үүрэг хангагдаагүй байгаад байна тийм ээ. Тайланд тайлбар нь болохоор тухайн заалтын хүрээнд хэрэгжүүлсэн, зохион байгуулсан ажил нь тодорхой бус, хэрэгжилт хангалтгүй талаар шалтгаан нөхцөлийг тайланд дурдаагүй тул хэрэгжээгүй гэж дүгнэсэн гэж байна. Тэгэхээр ер нь аливаа зүйл дээр бид хэн хариуцлага хүлээх юм, юунаас

алдаа нь гарсан юм гэдгийг тодорхой тусгаж гаргаж ирдэг баймаар байна. Энэ дээр асуулт.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Учрал сайд.

Н.Учрал: Өмнө жил Байнгын хороон дээр Хяналт хэрэгжүүлэх Үндэсний хороо гэж байсан. Тэгээд хуулийнхаа хүрээнд тэд л тайлангаа тавьж байсан л даа. Тийм, тэгэхэд тэгээд тэгж ярьж л байсан юм шиг байгаа юм. Тэгээд өнөөдөр нэг ийм байдалтай л байна. Миний хувьд Эдийн засаг, хөгжлийн сайдаар томилогдоод энэ хяналтын асуудал миний эрхлэх асуудлын хүрээнд ирсэн. Тэгээд ингээд өнгөрсөн 4 сарын хугацаанд хяналт хэрэгжүүлэх энэ тогтолцооны хувьд нэг эргэж харъя гээд үнэлгээ мониторинг, энэ мэдээллийн сангуудыг нэгтгэх, дээрээс нь 5 жилийн чиглэл буюу ирэх 5 жил Монгол Улс хэрхэн хөгжих вэ 5 жилийн үндсэн чиглэлийг боловсруулах ажлыг л хийж гүйцэтгэлээ. Тэгэхээр 5 жилийн чиглэл харьцангуй ийм индикаторууд тавьчихсан, хэмжиж болохуйц тодорхой үр дүнтэй байгаа.

Гэхдээ Их Хуралд ороод ирэхээр Их Хурлын ажлын хэсэг байгуулагдаад, тэгээд нөгөө зарчмын зөрүүтэй янз бүрийн санал гараад, бас танихын аргагүй болчихвол хэцүү. Тэгэхээр би гишүүдээсээ хүсээд байгаа зүйл нь энэ 5 жилийн чиглэлийн концепцыг нь алдагдуулахгүйгээр баталж өгөхөд анхаарч өгөөч. Нэг ийм хэмжигч болохуйц индикатортай, чиглэлтэй болчихвол түүндээ суурилсан жилийн төлөвлөгөө чинь өөрөө хэмжиж болохуйц болно. Хэмжиж болно гэдэг бол эргээд тайлагнах нь хүртэл тоогоор хангалттай, хангалтгүй гэдэг, хэрэгжсэн, хэрэгжээгүй гэдэг хоёрхон үзүүлэлттэй болохгүй бол тэгээд яг ингээд нэг ийм тайлан хэн сайн ирүүлснээрээ л бараг хангалттай гэж үнэлэгдэх гээд байна шүү дээ. Нөгөө үр дүн гараагүй, тэгсэн мөртөө нэг маш олон нэг хэлэлцүүлгүүд хийсэн, тэгээд л нэг арга хэмжээ зохион байгуулснаараа ингээд үнэлээд л яваад байдаг. Тэгээд энэ report-оо хэн сайн тавьж байгаагаараа үнэлүүлдэг л болчихоод л байна л даа. Тэгэхээр энэ дээр зайлшгүй яах аргагүй анхаарч явах ёстой.

Тэгэхээр ирэх жил дахиад нэг ийм юм яриад суухгүйн тулд бүгдээрээ ер нь энэ Их Хурлын Тамгын газар, ЗГХЭГ хамтын ажиллагаагаа их сайжруулах хэрэгтэй юм байна. Тэгээд энэ түрүүн хэлээд байгаа энэ кодификац энэ тэрээ хийж хэвшмээр байна. Үр дагаврын үнэлгээгээ хийдэг болмоор байгаа юм. Тэгэхээр Засгийн газар өөрсдийнхөө эрхлэх асуудлын хүрээнд эхлээд хийж болох зүйл нь 5 жилийн чиглэлээсээ эхэлье гэж ажил аваад анхны зорилго байсан. Тэгээд энэ байдлаараа ямартай ч ингээд эхлүүлчихлээ.

Зүгээр Эрдэнэс Тавантолгой компанитай холбоотойгоор яг ийм юм байгаа юм л даа. Жишээ нь холбогдох гэрээ хэлцлүүдийг олон нийтэд нээлттэй болгосон уу гэвэл болгосон. Жишээ нь гэрээнүүд нь тавигдаад, мэдээллүүд нь ил тод ингээд явж байгаа. Тэгээд 100 хувь хангалттай юу, үгүй юү гэдгийг нөгөө яаж үнэлэх нь тодорхойгүй ийм чиглэл авагдчихсан. Гэхдээ яг нөгөө олон нийтийн компани болсон уу гэвэл бас болоогүй. Тэгээд хангалтгүй. Гэхдээ хүрэхүйц үр дүндээ хүрч байна уу гэвэл ахиц дэвшилтэй. Тэгэхээр анхнаасаа Байнгын хорооны тогтоол олон нийтийн компани болоод бэлтгэл ажлыг хангах чиглэл өгөгдсөн үү, эсвэл яг олон нийтийн компани болоод үйл ажиллагаа явуулж эхэлсэн үү гэдгээ ийм ялгаж, салгахгүй болохоор ийм хэт их ерөнхий чиглэлүүд өгөгдчихөөр бид яг түүнийг нь биелүүлэх гээд явахаар нөгөө нэг харахаар биелэгдээгүй юм шиг, нэг харахаар биелэгдчихсэн юм шиг, хэмжиж болохуйц үр дүн ерөөсөө гарч өгөхгүй байгаа юм. Тэгэхээр энийг

бүгдээрээ хаана хаанаа ярьж шийдвэрлэж явбал ирэх жил ч гэсэн арай ахиц гарна гэж ингэж бодож байгаа.

Саяын тэр бараг 1374 заалт хэрэгжээгүй энэ тэр гээд яригдаад байгаа асуудлууд дээр саяын яригдсан энэ тогтоолууд дээр яг биелэлт яаж үнэлэгдсэн бэ гэдэг талаар ажлын хэсэг нэмж хариулна.

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн 5 номерын микрофон.

Б.Батцэцэг: Гишүүний асуултад хариулъя. Гишүүний саяын дурдсан тогтоолуудын хувьд тодорхой хэрэгжилтүүд явчихсан. Зарим зохицуулалтууд нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн төсөл дээр тусгагдчихсан. Нөгөө тухайн байгууллагууд нь тэгээд тайлагна гэгчихсэн боловч нөгөө хууль нь батлагдаагүй болохоор хэрэгжээгүй тэг, хэрэгжилт тэг гээд явчхаж байгаа байхгүй юу. Тийм, харин тийм. Тэгэхээр нөгөө нэг нь хууль өргөн барих гэдэг тогтоол, нэг нь одоо тэр Эрдэнэс Тавантолгойтой холбоотой ч юм уу, зарим зохицуулалтыг нь тайлагнаж байгаа байгууллага нь хуулийн төсөлд саналаа суулгасан гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ чинь хэрэгжилт тэг. Тэгээд миний түрүүний яриад байсан нөгөө хэрэгжилтийн хувь 0-85 хувь тэр чигээрээ хэрэгжээгүй л гэж аваад байгаа болохоороо та нарт тараагдсан материал дээр хэрэгжээгүй тэг, хэрэгжээгүй тэг гарч ирж байгаа.

Ц.Сандаг-Очир: Сүүлийн 1 минутаа тодруулъя, Уянгахишиг гишүүн.

Г.Уянгахишиг: Энэ дээр харин жишээлбэл түрүүний нөгөө Хөгжлийн банктай холбоотой хариулт өгч чадах юм болов уу, үгүй юм болов уу? Нөгөө Хөгжлийн банкийг цогцоор нь иж бүрэн өөрчлөн зохион байгуулж, холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах төслийг боловсруулж, 23 онд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх гэдэг энэ тогтоолын хэрэгжилт байхгүй байна гээд. Одоо энэ чинь 25 он болчихсон. Тэгэхээр энэнээс хойшоогоо ямар нэгэн байдлаар хэрэгжээгүй гэж дүгнэсэн гэгчихсэн энийг бас нэг тайлбар авчихмаар байна. Тийм. Тэгээд ер нь яг энэ хэрэгжилтийг, тайланг үнэлсэн талаас нэг байр суурь авчихмаар байх юм. Тэгэхгүй бол нөгөө нэг яг ийм 2 хэрэгжсэн, хэрэгжээгүйн ийм нэг ийм зүгээр нэг тоогоор төчнөөнөөс төчнөөн хувь бол хэрэгжээгүй, тэгсэн бол хэрэгжсэн ч гэдэг юм уу ийм баймааргүй. Нөгөө түрүүний хэрвээ хуулийн төсөл өргөн барина гэгчихсэн бол өргөн барьсан л гэсэн үг шүү дээ. Тэгээд л дуусна шүү дээ. Тэгэхээр ийм байдлаар явахгүй бол ингээд бидний хувьд ч гэсэн, Байнгын хорооны гишүүдийн хувьд үл ойлгогдох.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Хөгжлийн банкин дээр хууль боловсруулагдаагүй бол биш, боловсруулчихсан, олон нийтийн хэлэлцүүлгүүдийг нь ч хийчихсэн. Гантөмөр сайдын үед тэр хэлэлцүүлгүүдийг нь хийгээд, өргөн барихад бэлтгээд дууссан юм байна лээ. Гэхдээ энэ тайлан дээр нөгөө өргөн бариагүй учраас хангалтгүй гээд л үнэлж байгаа. Бариагүй л бол бариагүй шүү дээ. Засгийн газрын тэр үнэлгээ хийх журам баталчихсан байгаа Засгаас. Тэгээд бид нөгөө Хөгжлийн банкийг бол өргөн барихад бэлтгэгчихсэн байсан. Гэхдээ нөгөө ажил аваад, дахиад ажиллах хэрэгтэй гээд Хөгжлийн банкны хууль дээр дахиад ажиллаж байгаа юм. Тийм учраас өргөн бариагүй, тэгэхээр хангалтгүй гээд үнэлэгдчихсэн. Энэ үнэлгээ хийх журмууд бол

Засгийн газраас батлагдсан журмаараа явж байгаа. Хөгжлийн банкны хууль боловсруулагдаад дууссан.

Ц.Сандаг-Очир: Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн асуултаа асууя.

Ц.Даваасүрэн: Энэ асуудал намайг Төсвийн байнгын хороог ахалж байхад орж ирсэн. Тэгээд бид хэлэлцээд буцаасан юм. Арай дэндүү бага хувьтай байгаа байхгүй юу, 20 хэдэн хувьтай байсан санагдаж байна. Ер нь сүүлийн үед ингээд хараад байхад энэ тогтоолын хэрэгжилтүүд маш муу болсон байна. Бүр тэр дотроо Түр хорооны тогтоолыг бүр бичихгүй байгаа байхгүй юу. Түр хорооны тогтоол чинь ялгаа байхгүй Улсын Их Хурлын тогтоолтой адил үйлчилж байгаа шүү дээ.

Би Оюу толгойн түр хороог ахалж байхдаа хэд хэдэн шийдвэр гаргасан. Тайлангууд дээр байхгүй байх жишээний. Тэгэхээр би энэ дээр яагаад ингээд байна вэ гэвэл энэ Рио Тинто гэдэг компани байна шүү дээ одоо ингээд л алт, зэсийн үнэ өсөөд л, Монголчууд өнөөдөр ингээд ноогдол авах хэмжээний болоод ирж байгаа юм л даа алтны үнэ чинь 3 дахин өсөөд. Тэгэнгүүт зээл авчхаж байгаа байхгүй юу. Гэтэл бид Улсын Их Хурлын 103 дугаар тогтоол манай Байнгын хорооны, тэр Түр хорооны тогтоолоор зээл авахыг нь зогсоо гэдэг ийм шийдвэр гаргасан юм. Зээл авахыг нь зогсоо гэж.

Нөгөө нэг заалт нь Дубайн гэрээг шүүх хүчингүй гэж үзсэн. Тийм учраас Их Хурал хүчингүй гэж үзэж шийдвэр гаргаад, хүчингүй гэж үзээд энэ гэрээг хүчингүй болго, тэр зээл авч байгаа хураамжийг бүгдийг нь зогсоо гэсэн байхгүй юу. Тэгсэн одоо болтол зогсохгүй байгаад байна шүү дээ. Тэгээд эд нар чинь ингээд ашигтай болоод ирэнгүүт нь нэмж зээл аваад байна шүү дээ, Их Хурал энийг зогсоо гэсэн байна шүү дээ. Яагаад ингээд Их Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэхгүй байгаад байгаа юм бэ? Энэ Засгийн газар эсвэл ийм шахалт үзүүлэхгүй байгаагаас болоод байна уу? Яагаад энэ Дубайн гэрээг хүчингүй болгох, зээлийг зогсоох асуудал үргэлжлээд байна вэ гэдэгт хариулт авъя.

Өмнө нь ингээд жишээлбэл тогтоол шийдвэр биелүүлэхгүй бол яадаг байсан юм гэхээр яг тухайн сайдыг бид яг тэр заалтыг нь яаж байгаад өргөчихдөг байсан байхгүй юу. Тэгээд энийг чинь ингээд буруу байна, сайд нарыг айлгаад байна, Засаг муу ажиллаж байгаа шалтгаан болж байна гээд ингээд сайдад хариуцлага тооцдог юм байхгүй болгоод хаячихсан шүү дээ. Тэгээд ажил сайжирсан уу гэж, үгүй ээ бид юмыг ерөөсөө үнэлж, дүгнэж цэгнэж л ярьдаг байх хэрэгтэй. Ингээд сайд огцруулах эрхээсээ Их Хурал татгалзжээ. Засгийн газар сайн болсон уу? Ингэж бид эргэж харж ярьдаг болмоор байгаа байхгүй юу. Гэтэл миний энэ Их Хуралд байх хугацааг харахад энэ тогтоолын хэрэгжилтийг хангах асуудал улам муудаад байгаа байхгүй юу. Бүүр сүүлдээ 30 хувь руу ороод ирсэн. Тэгээд нөгөө сайд нарыг хариуцлага тооцохгүй болохоор ажил сайжирна гэсэн чинь хааччихсан бэ? Тэгээд Ерөнхий сайд нь сайдууддаа хариуцлага тооцож чадахгүй болохоор энэ чинь бүүр дордчихлоо шүү дээ.

Тэгэхээр энэ гишүүд асуугаад байна л даа. Ингээд тогтоол шийдвэрийн биелэлтийг харьяа юу, биелүүлэхгүй бол яадаг юм бэ гэж хариуцлага тооцдог л байхгүй юу. Тэгээд тэр Үндсэн хуулийн өөрчлөлтөөр Ерөнхий сайд өөрсөдтэйгөө хариуцлага, өөртэйгөө л хариуцлага тооц, битгий миний Засгийн газрын гишүүдэд хариуцлага тооцоод байгаач гээд энэ эрхийг авсан байхгүй юу. Тэгэхээр 103 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангахгүй юм бол.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Нэмэлт 1 минут, Даваасүрэн гишүүн.

Ц.Даваасүрэн: Тэр Түр хорооны 103 дугаар тогтоолын Дубайн гэрээг хүчингүй болгоод, бусад зээлүүдийг нь хүчингүй болго, зээл авахыг нь зогсоо гэсэн энэ заалтыг хэрэгжүүлэхгүй юм бол зүгээр одоо яах вэ танай Засгийн газар хэдхэн сар ажиллаж байгаа учраас би нэг их олон юм яриад яах вэ. Ирэх хавар би энэ тогтоолыг биелүүлээгүйн төлөө Засгийн газрыг огцруулах гарын үсэг цуглуулна шүү. Дубайн гэрээг хүчингүй болгох асуудлыг хэрэгжүүлэхгүй бол, зээл авахыг нь зогсоохгүй бол. Одоо эд нар чинь энэ тогтоол гарснаас хойш 3 тэрбум долларын зээл авчихсан байгаа шүү дээ. Зээл авахаар яаж байна Монголын нөгөө ноогдол ашиг авах хугацаа чинь хойшлоод л байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ асуудал дээр би хариуцлага нэхнэ ирэх хавар. Энэ удаа би та нарыг богино хугацаанд ажиллаж байгаа учраас хэрэгжүүлээч гэж дахин сануулж байгаа юм шүү.

Ц.Сандаг-Очир: Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Тийм, ер нь Их Хурлаас баталсан тогтоол, Байнгын хорооноос баталсан тогтоол хуультай адил хүчин төгөлдөр үйлчлэх ёстой, Түр хорооноос баталсан тогтоол ч тэр. Яагаад гэхээр бид чинь хуульдаа угаасаа Түр хороо Байнгын хорооны эрхлэх асуудлыг л хариуцна гээд заачихсан шүү дээ. Тэгэхээр Түр хорооны тогтоол ч тэр, Байнгын хорооны тогтоол ч тэр яг адилхан эрх зүйн акт мөн байхгүй юу. Тийм учраас биелүүлэх үүрэгтэй. Тэр ч утгаараа бид энэ Хяналт хэрэгжүүлэх газар, дээрээс нь энэ хууль тогтоомжтой холбоотой тогтоомжийн хэрэгжилтийг хангахдаа тэр 103 дугаар тогтоолыг хангалтгүй гэж үнэлээд л явж байгаа юм. Тэгэхээр энэ бол яг хариуцлага тооцох үндэслэл мөн. Тэгээд би Даваасүрэн гишүүнтэй санал нэг байгаа.

Ер нь Засгийн газрыг хариуцлагагүй ажиллаж байна гэж шаардлага тавих үндэслэл бол ерөөсөө л Байнгын хорооны тогтоол биелүүлээгүй, Их Хурлын тогтоол биелүүлээгүй, хууль биелүүлээгүй л гэдэг энэ шаардлагыг тавина шүү дээ. Тэгэхээр хэрвээ эхний үед үнэхээр Байнгын хорооны тогтоол биелээгүй гээд Байнгын хороон дээр бид орж ирээд тайлагнахад биелүүлээгүй байвал тэр өөрөө Ерөнхий сайдын асуудал. Тэгэхээр шаардлагатай сайд нартаа хариуцлага тооцоод явах нь эхний асуудал байгаа байхгүй юу.

Тийм учраас яг таны хэлсэн энэ 103 дугаар тогтоол дээр ч гэсэн тухайн үед нөгөө Оюу толгойн ТУЗ-д байгаа хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж байгаа ТУЗ-ийн гишүүд ч гэсэн дэмжээд л энэ тогтоолыг батлуулсан. Энэ тогтоол бидний хувьд Оюу толгойн хэлэлцээрийг хийхэд яг гаргаж тавих хөзөр мөн шүү дээ. Одоо ч гэсэн энэ 103 дугаар тогтоолыг тойроод л бид нэгэнт Их Хурлаас бидэнд чиглэл өгчихсөн, тогтоол гарчихсан, нэмэлт зээл авахгүй гэдгийг энэ тогтоолыг барьж л шаардаж байгаа. Тэгэхээр энийгээ ер нь Их Хурал Засгийн газар хоёрын харилцах харилцаа бол Их Хурлаас баталсан Байнгын хорооны тогтоолыг яагаад Засгийн газар биелүүлэхгүй байгаа юм бэ гээд хяналт тавих механизмаа хаана хаанаа хэрэгжүүлж явъя. Би Даваасүрэн гишүүнтэй 100 хувь санал нэг байна.

Ер нь Их Хурлын энэ гаргаж байгаа тогтоол шийдвэрүүд, Засгийн газрын гаргаж байгаа хэм хэмжээний актууд бүгдээрээ нэг сав руу орно, тэр үнэлгээ дээр тавигдаад, тэгээд ерөөсөө систем дээрээ уялдаад орж ирээд л, Засгийн газар 37 хувь, тэдэн хувь хангалтгүй байсан. Үүн дээр Их Хурлын Тамгын газар харин миний

түрүүн яриад байгаагаар манлайлал үзүүлж өгөөч, 103 дугаар тогтоол бол маш ойлгомжтой байхгүй юу үнэлэхэд. Зарим тогтоолууд хэт их ерөнхий болчихоор нөгөө ингээд үнэлгээг бид тойроод байна шүү дээ, ажил хийгээгүй биш бид хийсэн юм гээд тайлбарлаад, тэгээд нэг хэдэн хувийн үнэлэлт өгөөд байдаг. 103 дугаар тогтоол бол биелсэн, биелээгүй л гэдэг ийм зарчмыг тойрно гэж бодож байгаа. Тийм учраас Эдийн засгийн байнгын хороон дээр энэ тайланг тавина. Тэр 103 дугаар тогтоол хэрэгжсэн, үгүй дээр. Тэгээд Байнгын хороо хангалтгүй гэж үнэлээд, гишүүд нь саналуудаа хэлээд, энэ протоколд үлдээд ингээд явж байгаа. Тийм учраас таны би саналыг дэмжиж байна.

Ер нь ийм байдлаар бие биедээ хариуцлага яриад явъя. Тэгж байж цаашаа хууль дүрэм хэлбэрэлтгүй хэрэгжинэ. Тэгээд хуулийн үр дагаврын үнэлгээгээ манай Их Хурал, Засгийн газар хийх хэрэгтэй. Кодификация ч хийх хэрэгтэй, заалтуудынхаа уялдааг ч хангах хэрэгтэй. Байнгын хорооны тогтоол гаргаж байгаа дээрээ бидэнд хэмжигдэхүйц, цаг хугацаатай үүрэг өгөөд хэвшье. Тэгээд Засгийн газар хариуцлагаа яриад явдаг энэ механизм руу хамт явъя. Үүн дээр манай нэгэнт төлөвлөж байгаа, төсөвлөж байгаа, хянаж байгаа, мониторинг хийж байгаа эрх үүрэг нэг яаман дээр ирсэн учраас бид эргээд та бүхэнд үүнийгээ тайлагнаад явдаг энэ жишиг рүү оръё. Одоо бол 4 сарын хугацаанд ямар ч байсан ийшээ авчрах гээд нэлээдгүй хичээж ажиллаж байгаа. Тэгээд эхний үр дүн бол 5 жилийн чиглэлээс би харагдана гэж бодож байгаа.

Ц.Сандаг-Очир: Сүүлийн 1 минутаа тодруулъя, Даваасүрэн гишүүн.

Ц.Даваасүрэн: Тийм, ер нь та нар ингээд нөгөө Түр хорооны тогтоолыг Байнгын хороогоо түлхүү яриад орхичхоод байгаа байхгүй юу, болохгүй, адилхан. Тийм учраас би тэр Түр хорооноос Их Хурлаас гаргасан 103 дугаар тогтоол хоёрын энэний биелэлтийг заавал хангаач. Хангахгүй бол ирэх хавар гарын үсэг цуглуулна гээд байгаа нь тэр. Тэгээд нөгөө талаасаа одоо ингээд шаардлагатай юм бол тэр сайд нартайгаа хариуцлага ярь энэ асуудлуудаар, яаралтай зогсоо. Би дөрөвхөн сар ажиллаж байгаа учраас юм нэхэхгүй байна шүү. Ирэх хавар бол нэхнэ. Ингэж байж бид энэ ард түмэндээ тэр ноогдол ашгийг иргэддээ өгнө. Тэгэхгүй бол чадахгүй нөгөө зээлийн хүүд л төлөөд байна шүү дээ бид. Тэгээд энэ асуудлыг нэг та бүгд сайн анхаараач гэж. Тэгэхгүй бол нөгөө Засгийн газар нь хууль зөрчөөд л яваад байдаг, Их Хурал нь хариуцлагаа нэхэж чаддаггүй ийм увайгүй байдлаар бид цаашдаа яваад байвал энэ ашигтай ажиллуулна, ашиг орлого.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Санал хэллээ. Ганц нэг зүйл асууя. Энэ шийдвэрийн биелэлтүүдийг Тэргүүн Шадар сайд ингээд тавих нь зөв юм уу? Танайд эрхлэх асуудлын хүрээнд нь, Хэрэг эрхлэх газар чинь уг нь хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангадаг газар биш билүү? Тэгээд Бямбацогт сайд чинь, Хэрэг эрхлэх газар чинь яг юу хийж байгаа юм бэ? Яагаад Шадар сайд Учрал, Тэргүүн шадар сайд, эдийн засгийн асуудал хариуцсан сайд ингээд та биелэлтийг оруулж ирээд, хамгаалаад ингээд яваад байгаа юм бэ? Цаашдаа ийм болчихсон юм уу гэдгийг нэгд тодруулж асууя?

2-т энэ Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 115.2.17 дээр Засгийн газар дахь хяналт шалгалтын ажлын ерөнхий дүнг Төрийн байгуулалтын байнгын хороо жил бүр сонсоно гээд байгаа. Энийг хэзээ оруулж ирэх билээ? Энийгээ та бүхэн мэдэж байгаа байх гэж.

3-д Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль гэж байгаа бид баталсан. Энэ оны 6 сарын 1-нээс хэрэгжих ёстой байсан, хэрэгжилтийг хангалтгүй байна, бэлтгэл ажил хангагдаагүй байна гэдэг үндэслэн асуудал оруулж ирээд Засгийн газраас энэ хуулийн хэрэгжилтийг нэг жилээр хойшлуулсан. Ирэх оны 6 сарын 1-нээс байгаа байх. Энэ хуулийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр Засгийн газраас өнгөрсөн хугацаанд хуулийг хойшлуулаад нэг жилээр ямар ажил хийв? Ахиад ирэх жилийн 6 сарын 1 гэхэд нэг жилийн дараа ахиад биелэлт хангалтгүй, бэлтгэл ажил хангагдаагүй, энэ чиглэлээр ажил явсангүй гээд ингээд ороод ирэх юм биш биз дээ? Энэ хуулийн энэ хэрэгжилт дээр яаж анхаарч ажиллаж байна вэ гэсэн ийм 3 асуулт дээр хариулж өгөөч? Учрал сайд.

Н.Учрал: Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний хуулийг сая шинэ Засгийн газар өргөн мэдүүлэхдээ энэ Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх чиг үүргийг Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудалд хамааруулсан хэдий ч Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх хуульдаа хууль тогтоомж, шийдвэрийн биелэлтийг ЗГХЭГ хариуцна. Хөгжлийн бодлогын төлөвлөлтийн асуудлыг хянах чиг үүргээ Эдийн засаг, хөгжлийн яам хариуцна буюу бид 5 жилийн чиглэл, улсын жилийн төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг боловсруулдаг бол эргээд үүндээ хяналт тавих, дээрээс нь Засгийн газраас гаргаж байгаа хэм хэмжээний актууд, Их Хурлын бодлого, шийдвэрүүд хөгжлийн бодлоготой нийцэж байгаа эсэх дээр хяналт тавих, хууль тогтоомж дээр ч гэсэн, нэг ёсондоо 5 жилийн чиглэлийн үндсэн концепцтой нийцэж байна уу, жилийн төлөвлөгөөтэй нийцэж байна уу гэдэг дээр нөгөө төсөв дээр өгдөг зөвшөөрөлтэйгөө адилхан үнэлэлт дүгнэлт өгөх, мониторинг хийх эрх, үүрэг нь Эдийн засгийн хөгжлийн яаман дээр байгаа юм.

Тэгэхээр яг хууль тогтоомж, шийдвэрийн биелэлттэй холбоотой асуудлыг Хэрэг эрхлэх газар хариуцна гэж ойлгож болно. Яах вэ би бол зүгээр Хяналт хэрэгжүүлэх газар манай дэргэд байна. Дээрээс нь хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд үнэлгээ хийж байгаа гэдэг утгаараа Тэргүүн шадар сайдын хувиар энэ тайланг тавьж байна. Ер нь Хэрэг эрхлэх газар хууль тогтоомж, шийдвэрийн биелэлтийг хариуцдаг чиг үүрэг бол хэвээрээ гэдгийг хэлье.

2-т тэр Хот, тосгоны эрх зүйн байдлын хуулийг яг батлуулахад 2024 онд энэ Ажлын хэсгийг би өөрөө ахалсан. Тэгээд Сандаг-Очир гишүүн манлайлж ажилласан, бид хамт ажилласан. Засгийн газрын Хэрэг эрхлэхийн сайдаар томилогдоод яг үнэн тухайн үед бэлтгэл ажлыг хангаагүй, төсөв мөнгө хүрэлцээгүй, цаг хугацааны хувьд ийм боломж байсангүй гэдэг утгаараа сонгуулийн дараах ийм жил гэдэг утгаараа бид жилээр хойшлуулсан. Одоо бол дахиад жилээр хойшлуулах эрх байхгүй. Тэгээд зөв гэж үзээд, түгжрэлийг бууруулахад бодитой өөрчлөлт өгнө гэж үзээд, энэ Налайх, Багануурыгаа улсын зэрэглэлтэй хот болгоно гэж шийдээд, тэгээд тэр Нийслэлийн эрх зүйн байдлын хууль, энэ Хот, тосгоны хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хууль гээд энэ чинь бид концепцын өөрчлөлт хийнэ гээд 2024 онд иргэддээ ч гэсэн амлачихсан олон амлалтууд байгаа.

Засгийн газрын 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөр дээр ч гэсэн тухайн үед нөгөө Хэрэг эрхлэхийн сайдаар ажиллаж байсан учраас 4 жилийн хөтөлбөрийг боловсруулахдаа энэ Хот, тосгоны эрх зүйн байдлын асуудлыг тусгуулсан. Ингээд одоо энэ ажлыг аймаг, орон нутаг, нутгийн захиргааны байгууллагуудыг хариуцах чиг үүрэгтэй Хэрэг эрхлэх газар бэлтгэл ажлыг хангуулан ажиллаж байгаа. Одоо бол энэ хуулийг хойшлуулах ямар ч цаг хугацаа байхгүй. Тийм учраас сая Хяналт хэрэгжүүлэх газар энэ Хот, тосгоны эрх зүйн байдлын хуулийн хэрэгжилт хангалтгүй

гэж дүгнэж оруулж ирсэн. Хот, тосгоны эрх зүйн байдлын хууль хангалтгүй байна гээд. Хэрвээ энэ дахиад хангалтгүй байвал түрүүний Даваасүрэн гишүүний хэлдэг шиг хариуцлага ярья л гээд сууж байх ёстой байхгүй юу бид. Тэгвэл хаана хаанаа, хэн хэндээ энэ хариуцлагатай болно.

Тийм учраас Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга та үүн дээр ер нь нэг бэлтгэл ажлыг хангуулах чиглэлээр Байнгын хороон дээрээ нэг ажлын хэсэг хамтарч гаргаад ч юм уу, бүгдээрээ нийлээд энэ богино хугацаанд ажиллая. Тэгэхгүй бол бас яг нэг ийм дундаа нэг ийм эзэнгүйдэх байдал хаана хаанаа ажиглагдаж байгаа. Тэгэхээр тантай энэ дээр хамтарч ажиллая.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Тэр 115.2.17-г Төрийн байгуулалтын байнгын хороогоор оруулж ирэх хуультай шүү дээ. Ажлын хэсгийн 5 номер.

Б.Батцэцэг: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Бид 2025 онд хийгдсэн хяналт шалгалтын ажлууд болон энэ оны эхээр хийгдсэн хяналт шалгалтын ажлын гүйцэтгэлийн хяналтыг хийгээд явж байна. Бидний тооцоолж байгаагаар 11 сарын 20-ны өдөр сүүлийн хяналт шалгалтын тайлан гарах юм. Тэгэхээр тэрнээс хойш 25 оны туршид хийгдсэн хяналт шалгалтын ажлын тайланг танилцуулна гэж төлөвлөөд ажиллаж байгаа. Одоогоор 4 хяналт шалгалт явж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ ажлууд дуусаад, тэгээд 11 сарын 20-ноос хойш.

Ц.Сандаг-Очир: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хууль тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлантай холбогдуулан үг хэлэх гишүүд нэрээ өгнө үү? Уянгахишиг гишүүнээр тасаллаа. Бадамсүрэн гишүүн үгээ хэлье. Уянгахишиг гишүүн, ирцээрээ юм байна, Уянгахишиг гишүүний микрофоныг өгье.

Г.Уянгахишиг: Ерөнхийдөө түрүүн нөгөө тайлбар юмнуудаа сонслоо. Тэгээд Их хурлаас Их Хурлын Тамгын газраас ерөнхийдөө нөгөө тайланд үнэлэлт дүгнэлт өгчихсөн гэж ойлгож байгаа шүү дээ тийм ээ, тийм. Тэгэхээр энэ арга зүй нь болохоор Засгийн газрын 25 оны 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж, дүгнэх журам гэж байгаа байхгүй юу. Тэгээд тухайн журмын 3.7-д заасан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг дүгнэх аргачлалыг удирдлага болгоно гэж байна. Тэгэхээр энэ өөрөө нөгөө саяын яриад байгаа тэр аргачлал нь болохгүй байгаад байгаа юм, эсвэл нөгөө дүгнэхэд төвөгтэй байгаа юм, тэгээд энэ аргачлалаасаа болоод ийм бага хувьтай дүгнэгдчихлээ ч гэдэг юм уу иймэрхүү асуудал уг нь цаашдаа баймааргүй байгаа байхгүй юу.

Тэгэхээр өөрөөр хэлбэл Засгийн газрын үйл ажиллагааг өөрсдийнх нь Засгийн газраас баталсан аргачлалынх нь дагуу дүгнээд байна шүү дээ. Тэгэхээр хэрвээ шаардлагатай бол энэ аргачлалаа өөрчлөөч. Тэгээд ерөнхийдөө энэ тайланг хэлэлцээд дүгнэнэ гэдэг маань юу гэсэн үг вэ гэхээр тэр өгсөн чиг үүрэг, ажил даалгаврыг хэрхэн гүйцэтгэсэн бэ гэдгээс чинь уялдаад хариуцлага тооцогдож байх ёстой. Тэгэхгүй бол наадах чинь угаасаа нэг аргачлалаасаа болоод хийсэн юм ч хийсэн гэж үнэлэгддэггүй юм. 31-ийг нь нэг их тэгж бодоод хэрэггүй дээ ч гэдэг юм уу нэг иймэрхүү байдлаар байгаад байвал тэнчээ хүн цаг зарцуулаад, тайлан гаргаад, тэрийг нь нэг хянасан болоод ч байх ямар хэрэг байх юм.

Тэрнийх нь дагуу гарч ирсэн дээр ямар ч хариуцлага яригддаггүй, тооцогддоггүй байвал энэ чинь өөрөө дахиад ямар ч хэрэггүй, бүтээмжгүй асуудал болж байгаа байхгүй юу. Тэгэхээр энийгээ буцаагаад нөгөө Учрал сайд зөндөө ярьдаг даа ер нь нөгөө бүтээмжийн асуудлаа хэдүүлээ ярилцахгүй бол болохгүй. Төрийн алба үнэхээр төрийн албан дээр байгаа ажилтнуудын бүтээмжийн асуудал яригддаг. Тэгэхээр энэ бүтээмж чинь өөрөө яг л ийм нөгөө тайлан төлөвлөгөө, тайлангийн үнэлгээ буцаад яг энэ юман дээрээ KPI чинь өөрөө тооцогдож үнэлэгдэж байх ёстой. Үүгээрээ тэр албан тушаалтнууд дээр чинь хариуцлага тооцогддог байх ёстой. Үнэхээр албан тушаалтан нь шийдвэрээ гаргаагүй юм уу, эсвэл ажилтан нь хий гэсэн ажлыг хийгээгүй юм уу. Тэгэхээр энэ болгон дээр чинь төрийн албан хаагчид дээр хариуцлага тооцогддог баймаар байна. Албан тушаалтнууд дээр тооцогддог баймаар байна. Энэ үнэлгээ нь өөрөө аргачлал нь зөв байдаг баймаар байна.

Байнгын хороон дээр орж ирээд тайлагнаж байгаа асуудлууд дээр буцаагаад наадах чинь хэрэгжээгүй гээд биччихсэн, гэхдээ хэрэгжихсэн юм гэдэг ийм тайлбар дахиад сонсмооргүй байна. Тэгэхээр энийг яг анхааралдаа аваад, аливаа ажилд чинь хүн цаг, хөрөнгө санхүү бүх юм зарцуулагдаж байдаг. Үр дүнтэй баймаар байна. Хэдүүлээ аль, аль талдаа энэ тал дээр анхаармаар байна гэж хэлье.

Ц.Сандаг-Очир: Бадамсүрэн гишүүн.

М.Бадамсүрэн: Байнгын хорооны болон Түр хорооны тогтоол заавал биелэгдэх шинж чанартай гарч байгаа. Гэхдээ дотооддоо буюу хууль тогтоогчоос Байнгын хорооноос эрхлэх асуудлын хүрээнийхээ Засгийн газар, холбогдох байгууллагуудад. Тэгэхээр яах вэ надад зүгээр ийм санал байгаа юм. Хуулийн төсөл санаачлахад Засгийн газраас буюу энэ хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах энэ байгууллагуудаас санал авдаг урьдчилж, 30 хоногийн дотор хариугаа ирүүлээгүй бол санал өгсөнд тооцдог. Тэгээд энэнтэй адилхан ер нь яах вэ Байнгын хороо, Түр хороо тогтоол гаргахаасаа өмнө энэ тогтоолын хамрах хүрээ, энэ тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотой ямар зардал гарах юм, хууль, эрх зүйн ямар үр нөлөө үзүүлэх юм гэдэг талаар урьдчилж санал авдаг энэ зохицуулалтыг хуульчилж тусгавал илүү оновчтой юм байна л гэж бодож байна, бодогдож байна.

Тэгэхгүй болохоор Байнгын хорооноос тогтоол гаргачихдаг. Тэгээд энэ маань янз бүрийн шалтгаан дурдсан байна шүү дээ энэ ирүүлж байгаа тайлан дээрээ хөрөнгө санхүү, бусад хүчин зүйлийн талаар. Ингээд зохицуулалтыг, хуулийн зохицуулалтыг хийгээд өөрчилчихвөл харин хуультай адил биелүүлэхгүй байвал нэлээн хатуу хариуцлага тооцдог энэ зарчим руугаа орвол илүү оновчтой юм уу л гэж бодож байна.

Ер нь яах вэ хараад байхад ингээд өмнө үйлчилж байсан хууль тогтоомжуудыг цаг үеийн нөхцөл байдалтайгаа уялдуулж, мөн хэрэгжих явцад гарч байгаа аливаа зүйлүүдтэй уялдуулж энийг тогтмол байнга шинэчилж явах нь зөв юм байна гэдэг нь бол алхам тутамд харагдаж байгаа. Тийм учраас бид Дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах саналыг өргөн барьсан. Сая ч гэсэн энэний өмнө хэлэлцэх хамтарсан хуралдаан дээр хэлэлцэх асуудал дээр энэ Улсын Их Хурлын гишүүний 12 сар хүртэл хугацааны тэтгэмж олгодог энэ зохицуулалттай холбоотой иргэд санаачлаад явж байна. Тэгээд иймэрхүү зүйлүүдийг бид урьдчилж соргоогоор харж, ялангуяа манай Байнгын хороо, мэргэжлийн энэ хороод өөрсдөө энэ асуудлыг түрүүлж авч санаачилж хэрэгжүүлээд, ингээд шийдвэрлээд, зохицуулаад,

уялдуулаад, тэгээд ингээд үр дүнтэй болговол энэ ямар нэгэн асуудал гацаа гарахгүй гэж үзэж байгаа.

Хууль гэдэг амьдралын явцад үргэлж сайжирч явах ёстой болохоос биш тэдэн жилийн өмнө тийм байсан энүүгээрээ явсаар л ирсэн, тэгээд өмнө болоод л байдаг байсан гэдэг зарчмаар асуудалд хандаж болохгүй. Тийм учраас манай Байнгын хорооноос энэ чиглэлээр хуулийн төсөл санаачлах ийм тодорхой саналтай байгаа бол би орж ажиллахад бэлэн байна. Шаардлагатай гэж үзээд энэ дээр тодорхой ёстой жинхэнэ ажлын хэсэг гаргаад, энийг үр дүнтэй болгохын тулд санал боловсруул гэвэл орж ажиллахад бэлэн байна. Тэгэхгүй болохоор ингээд яг ингээд олон жил сонссон байгаа л даа энэ тогтоолын биелэлтийг. Тэгээд нэг сонссон болоод л, тэгээд л энэ нь нэг биелэгдсэн, биелэгдээгүй, нэг талаасаа тайлбар хэлдэг, нөгөө талдаа биелүүлсэнгүй гэдэг. Тэгээд энийг бодитой, үр дүнтэй, ёстой смарт болгохын тулд холбогдох хууль тогтоомжуудад өөрчлөлт оруулж, урьдчилж санал аваад, тэгээд л шийдвэр гаргасан. Гаргасан шийдвэрийг заавал хэрэгжүүлдэг, ямар нэгэн тайлбар сонсдоггүй, хүлээж авдаггүй байх ийм зохицуулалттай болгох саналыг дэвшүүлж байна. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Хяналт шалгалтын тухай хууль 20 онд батлагдсанаас хойш харин ингэж Байнгын хороодоор хууль, тогтоолын хэрэгжилтийг хянадаг, биелэлтийг хянадаг ийм болсон шүү. Өмнө нь Хэрэг эрхлэх газар, Засгийн газраас биелэлтийг ирүүлээд л болчихдог байсан. Одоо бол Хяналт шалгалтын тухай хуулиар 20 оноос хойш Байнгын хороо, тэгээд шаардлагатай үед чуулганаар хэлэлцдэг болсон. Энэ нь нэг талын ахиц дэвшил гэж ингэж харж болно. Гэхдээ өнөөдрийн энэ тайлан, тогтоолын хэрэгжилт, биелэлтийн тайланг сонсоход Улсын Их Хурал нэг л зүйл дээр анхаарлаа хандуулж ажиллах ёстой юм байна л гэж бодож байна. Энэ баталсан хууль, Байнгын хороод баталсан тогтоол юмнуудын хэрэгжилт дээрээ сул ажиллаж байгаа юм байна.

Хууль баталчихдаг, тогтоол гаргачихдаг ингээд энэнийхээ араас асуудаггүй, сурагладаггүй, хянадаггүй, үздэггүй, үр дүнг нь тооцдоггүй ийм байдалтай яваад, үүний хэрэгжилт хангалтгүй байгаа юм байна. Энэ ажил дээрээ Их Хурал, холбогдох өөр өөрсдийн харьяалах асуудлаараа Байнгын хороод, тэгээд дэд хороод ч гэсэн орно, хяналтын хороо ч орно, ийм чиглэлээрээ энэ ажлаа дутуу, сул хийж байгаа юм болов уу гэсэн ийм ерөнхий дүгнэлттэй. Тийм учраас зөвхөн манай Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний хүрээнд ч гэсэн ингээд л 30 гаруй хувьтай хэрэгжилт, биелэлт ийм байна гэдэг нийтлэг бүх л Байнгын хороод Их Хурлын гаргасан, Байнгын хороодын гаргасан тогтоол, шийдвэрийн биелэлт ийм ерөнхий ийм дүнтэй л байна гэсэн үг.

Тийм учраас бид сая жишээ нь Учрал сайд хэлж байна. Манай эрхлэх асуудлын хүрээний хууль, баталсан хуулийн хүрээнд Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг хэрэгжүүлэх, хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр ажлын хэсэг гаргаж ажиллах шаардлагатай байна. Ойрын үед энэ чиглэлээр Засгийн газартай холбогдож, энэ хуулийн хэрэгжилтийн чиглэлээр сонсож, явцын талаар сонсож, цаашид эрчимжүүлэх чиглэлээр яаж ажиллах юм бэ гэдэг асуудлыг ярья. Бадамсүрэн гишүүний гаргаж байгаа ер нь энэ хууль тогтоомжийн хэрэгжилтийн биелэлтийг эрчимжүүлэх чиглэлээр ажлын хэсэг гаргаж, Их Хурал өөрөө ер нь ажлаа хийхгүй байгаа юм байна, энэ тал дээрээ сул байгаа юм байна. Сая Учрал сайд хэлж байна шүү дээ. Ёстой жинхэнэ энүүгээр ингээд шахаад, сайдуудыг, Засгийн газрыг энүүгээр шахаад, хэрэгжилтийг нь сонсоод, ингээд үнэхээр

хэрэгжүүлэхгүй байгаа бол арга хэмжээ аваад, хариуцлагын асуудал яригдаад явах нь нээлттэй байгаа гэж ингэж ярьж байна. Үнэн.

Тийм учраас Их Хурал цаашдаа Байнгын хороод бид энэ дээрээ хууль тогтоомжийн хэрэгжилтийн биелэлтийг хангуулах чиглэлээрээ, эрчимжүүлэх чиглэлээрээ ажлын хэсэг гаргах ийм саналтай байна. Энэ асуудлыг Байнгын хороон дээр ахиад ярья гэсэн ийм бодолтой байна гэдгийг хэлье. Ингээд өнөөдрийн хууль, тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг хэлэлцэж дууслаа.

14.49 цаг

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууслаа. Баярлалаа хуралдаа оролцсон гишүүдэд.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА